

ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА

SM-R530
SM-R630

Агуулга

Эхлэх

- 3 Galaxy Buds3 / Galaxy Buds3 Pro-гийн тухай
- 4 Төхөөрөмжийн харагдац ба функциуд
- 7 Зөөлөвчийг солих (Galaxy Buds3 Pro)
- 8 Зай цэнэглэх
- 15 Заагч гэрлийн тодорхойлох утга

Чихэвч хэрэглэх

- 18 Утасгүй чихэвчийг мобайл төхөөрөмжид холбох
- 22 Сүлжээ ашиглах
- 23 Утасгүй чихэвч зүүх
- 25 Утасгүй чихэвчийг дохиогоор хэрэглэх
- 28 Дуу чимээний хяналтын горимуудыг ашиглах
- 30 Орчны дуу руу автоматаар шилжих (Galaxy Buds3 Pro)
- 31 Дуу хөгжим сонсох
- 31 Тэнцвэржүүлэгч ашиглах
- 32 Дуудлагын функц хэрэглэх
- 32 Vixby

Galaxy Wearable хэрэглүүр

- 34 Танилцуулга
- 37 Galaxy Buds-ийн тохиргоог тохируулах

Хэрэглээний талаарх мэдэгдэл

- 45 Төхөөрөмжийг ашиглахтай холбоотой сануулга
- 46 Багцын агуулга, дагалдах хэрэгслийн талаарх тэмдэглэл
- 47 Ус ба тоосны эсэргүүцлийг хадгалах
- 48 Утасгүй чихэвчийг ашиглахтай холбоотой сануулга
- 49 Galaxy Buds-ийг цэвэрлэх, удирдах
- 51 Чихэвчийг унтрааж асаах
- 51 Чихэвчийг хослуулах

Хавсралт

- 52 Гэмтэл оношлох

ЭХЛЭХ

Galaxy Buds3 / Galaxy Buds3 Pro-гийн тухай

Galaxy Buds3 / Galaxy Buds3 Pro (цаашид Galaxy Buds гэх) нь утасгүй чихэвч бөгөөд та дасгал хийх гэх мэт өөр юм хийж байхдаа ч мобайл төхөөрөмжиндөө холбогдож дуу сонсох, дуудлагад хариулах боломж олгоно.




Автозам, явган хүний гарц зэрэг замын хөдөлгөөн ихтэй газар чихэвч зүүж болохгүй. Ингэх нь хариу үйлдэл үзүүлэх хугацаа удааширснаас болж осолд хүргэж болзошгүй.


Төхөөрөмжийн харагдац ба функциуд

Утасгүй чихэвч


► Galaxy Buds3:



► Galaxy Buds3 Pro:



Цэнэглэх хайрцаг



- Төхөөрөмжийг хэвийн ажиллуулахын тулд төхөөрөмжийг соронзон хөндлөнгийн оролцоогүй газар ашиглана уу.
- Таны төхөөрөмж болон зарим нэмэлт хэрэгсэлд (тусад нь худалдана) соронзон агуулагдаж болно. Кредит карт, суулгасан эмнэлгийн хэрэгсэл болон соронзны нөлөөнд өртөж болзошгүй бусад төхөөрөмжөөс хол байлга. Эмнэлгийн хэрэгслийн хувьд төхөөрөмжөө 15 см-ээс хол зайд байлга. Хэрэв та өөрийн эмнэлгийн хэрэгслийг нөлөөлж болзошгүй гэж сэжиглэж байгаа бол төхөөрөмжөө ашиглахаа зогсоож, эмч эсвэл эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэгчтэйгээ зөвлөлдөнө үү.
- Хэрэв таны зүрхэнд эмнэлгийн суулгац байгаа бол төхөөрөмжөө цээжний эсвэл хүрэмний дотор талын халаас гэх мэт суулгасан төхөөрөмжтэй ойрхон халаасанд хийж болохгүй.
- Соронзонд өртөж буй объектууд болон таны төхөөрөмж болон соронз агуулсан зарим хэрэгслүүд (тусад нь худалдана) хооронд аюулгүй зайг хадгал. Кредит карт, хадгаламжийн дэвтэр, нэвтрэх карт, онгоцны нэвтрэх карт, зогсоолд нэвтрэх карт зэрэг объектууд эвдэрсэн эсвэл төхөөрөмжийн соронзонг нь идэвхгүй болгосон байж болно.



Хэрэв чихэвч гэмтсэн байхад хэрэглэвэл бэртэх аюултай. Утасгүй чихэвчийг Samsung-н засвар үйлчилгээний төв эсвэл зөвшөөрөлтэй засвар үйлчилгээний төвд засуулсны дараа л дахин хэрэглэнэ үү.




- Товшит мэдрэгч дээр гаднын материал наалдсан бол мэдрэгчийг доголдуулахад хүргэж болзошгүй. Чихэвчийг зүүхээс өмнө мэдрэгчийг цэвэрлэнэ үү.
- Хэрэв цэнэглэх холболт шингэн, хөлсөнд норсон бол Galaxy Buds зэвэрч болзошгүй. Цэнэглэх холболт эсвэл утасгүй чихэвч шингэн, хөлсөнд норсон бол утасгүй чихэвчийг цэнэглэх хайрцагт хийхийн өмнө цэвэрлэ.
- Энэхүү гарын авлагад байгаа зургууд нь Galaxy Buds3 Pro-гийн зургууд юм.

Зөөлөвчийг солих (Galaxy Buds3 Pro)




- Чихэвчийг зөөлөвчгүйгээр чихэнд бүү хий. Ингэснээр чихийг өвтгөж болзошгүй.
- Зөөлөвч хийх, салгахдаа хүчтэй чангааж болохгүй. Зөөлөвч тасарч болзошгүй.
- Зөөлөвчийг хэт дарж, мушгиж болохгүй. Зөөлөвч гэмтэж болзошгүй.
- Зөөлөвчийг оруулах үед зөөлөвч нь чихэвчийн гадна талд харагдах жижиг завсарт хавчигдаж болзошгүй. Энэ тохиолдолд зөөлөвчийг аваад дахин суулгана.

1 Чихэвчин дэх зөөлөвчийг эргүүлж, зөөлөвчийн дунд хэсгээс босоогоор нь татаж аваад салгана.



- 2 Өөрийн чихэнд тохирсон зөөлөвч сонго.
- 3 Чихэвчийн чанга яригч дээрх цухуйсан хэсгийг зөөлөвчийн ховилтой зэрэгцүүлж, байрандаа орох хүртэл түлхэнэ.



Зай цэнэглэх

Анхны удаа эсвэл удаан хугацаагаар хэрэглээгүй орхисны дараа чихэвчийг хэрэглэхийн өмнө зайг бүрэн цэнэглэнэ. Чихэвч нь цэнэглэж байх үед ажиллаж эхэлнэ. Анх удаа зайг цэнэглэх эсвэл зайн цэнэг бүрэн дууссан бол дор хаяж 10 минут цэнэглэж байж ажиллахад бэлэн болно.


Дотроо зай хураагуур бүхий цэнэглэх хайрцаг нь цэнэглэгчид холбосон үед чихэвчийн хамт цэнэглэгдэнэ.




Хэрэв та чихэвчийг бүрэн цэнэггүй цэнэглэх хайрцагт хийвэл дуу чимээ гаргаж болзошгүй. Утасгүй чихэвч оруулахын өмнө цэнэглэх хайрцгийг хангалттай цэнэглэ.

Утастай цэнэглэх


- 1 Цэнэглэх хайрцгийг нээ.
- 2 Чихэвч бүрийн чиглэлийг шалгаж, цэнэглэх хайрцгийн харгалзах үүрэнд зөв байрлуулна.



- 3 Цэнэглэх хайрцгийг хаа.



- 4 USB кабелийг цэнэглэгчид холбоод USB кабелийг цэнэглэгч портод залга.




- 5 Цэнэглэгчийг цахилгааны залгуурт залга.
Утасгүй чихэвчийн зай болон цэнэглэх хайрцгийг зэрэг цэнэглэнэ.
- 6 Цэнэглэж дууссаны дараа цэнэглэх хайрцгийг цэнэглэгчээс салга. Эхлээд USB кабелийг цэнэглэгч хайрцагаас салгаж, дараа нь цэнэглэгчийг цахилгааны углуургаас салга.

Утасгүй цэнэглэх

Цэнэгэх хайрцаг дотор утасгүй цэнэглэх ороомог бий. Та утасгүй цэнэглэгч (тусад нь зардаг) ашиглан зайгаа цэнэглэж болно.

- 1 Цэнэглэх хайрцгийг нээ.
- 2 Чихэвч бүрийн чиглэлийг шалгаж, цэнэглэх хайрцгийн харгалзах үүрэнд зөв байрлуулна.
- 3 Цэнэглэх хайрцгийг хаа.

- 4 Цэнэглэх хайрцгийн ар талын утасгүй цэнэглэх ороомгийг утасгүй цэнэглэгч дээр голлуулж тавь. Утасгүй цэнэглэх нь дагалдах хэрэгсэл эсвэл гэрийн төрлөөс хамааран жигд ажиллахгүй байж болзошгүй. Тогтвортой утасгүй цэнэглэхийн тулд гэр эсвэл дагалдах хэрэгслийг Galaxy Buds-аас салгахыг зөвлөж байна.



- 5 Цэнэглэж дууссаны дараа утасгүй цэнэглэгчийг цэнэглэх хайрцгаас салга.



Утасгүй цэнэглэх санамжууд

Утасгүй цэнэглэгч дээр цэнэглэх хайрцгийг тавихдаа завсар нь дамжуулагч материал, тухайлбал металл биет, соронз зэргийг байрлуулж болохгүй. Galaxy Buds зохих ёсоор цэнэглэгдэхгүй эсвэл хэт халах юм уу цэнэглэх хайрцаг гэмтсэн байж болзошгүй.



Samsung-ийн зөвшөөрсөн утасгүй цэнэглэгчийг хэрэглэ. Хэрэв та бусад утасгүй цэнэглэгч хэрэглэвэл, зай ажиллахгүй байж магадгүй.


Утасгүй тэжээл хуваалцах замаар цэнэглэх

Та Galaxy Buds-аа утасгүй цэнэглэгчээр ажилладаг төхөөрөмжийн зайгаар цэнэглэх боломжтой. Та утасгүй цэнэглэгчээр ажилладаг төхөөрөмжийг цэнэглэж байхдаа ч Galaxy Buds-аа цэнэглэх боломжтой. Ашиглаж буй дагалдах хэрэгсэл эсвэл гэрийн төрлөөс хамааран Утасгүй тэжээл хуваалцах функц зөв ажиллахгүй байж магадгүй. Энэ функцийг ашиглахаасаа өмнө утасгүй цэнэглэгчээр ажилладаг төхөөрөмж болон Galaxy Buds-ийн ашиглаж байгаа гэрийг салгахыг зөвлөж байна.

- 1 Цэнэглэх хайрцгийг нээ.
- 2 Чихэвч бүрийн чиглэлийг шалгаж, цэнэглэх хайрцгийн харгалзах үүрэнд зөв байрлуулна.

3 Цэнэглэх хайрцгийг хаа.

4 Утасгүй цэнэглэгчийн үүрэг гүйцэтгэх төхөөрөмж дээрх Утасгүй тэжээл хуваалцах функцийг асаагаад, утасгүй цэнэглэгчийн үүрэг гүйцэтгэдэг төхөөрөмж дээрх цэнэглэх хайрцгийн ар талд утасгүй цэнэглэх ороомгийг голлуулж тавь.



5 Бүрэн цэнэглэж дууссаны дараа цэнэглэх хайрцгийг утасгүй цэнэглэгчийн үүрэг гүйцэтгэх төхөөрөмжөөс салга.



- Зөвхөн утасгүй тэжээл хуваалцах функцийг дэмждэг мобайл төхөөрөмжүүд Galaxy Buds-г цэнэглэж чадна. Утасгүй тэжээл хуваалцах функцийг дэмждэг мобайл төхөөрөмжүүдийг шалгахын тулд Samsung вебсайт руу зочилно уу.
- Утасгүй цэнэглэх ороомгийн байршил төхөөрөмжийг загвар бүрд ялгаатай байж болно. Төхөөрөмж, цэнэглэх хайрцгийг сайтар холбогдохоор тааруул.
- Бүрэн цэнэглэхийн тулд цэнэглэж байх үед утасгүй цэнэглэгчийн үүрэг гүйцэтгэх төхөөрөмж, цэнэглэх хайрцгийг бүү хөдөлгө.
- Та Galaxy Buds-ийг цэнэглэсэн тэжээлийн хэмжээ утасгүй цэнэглэх тавиурын үүрэг гүйцэтгэж буй төхөөрөмжөөс дамжуулсан хэмжээнээс бага байж болно.
- Хэрэв та утасгүй цэнэглэх тавиурын үүрэг гүйцэтгэж буй төхөөрөмжөөр цэнэглэнгээ Galaxy Buds чихэвчийг давхар цэнэглэвэл цэнэглэх хурд буурах юм уу цэнэглэгчийн төрлөөс хамааран Galaxy Buds зүй ёсоор цэнэглэгдэхгүй байж болзошгүй.
- Цэнэглэх хурд болон үр дүн нь орчин болон төхөөрөмжийн нөхцөл байдлаас хамаарна.
- Утасгүй цэнэглэгчийн үүрэг гүйцэтгэж буй төхөөрөмжийн зайн цэнэгийн хэмжээ тодорхой түвшнээс доошилбол цэнэг хуваалцахаа зогсооно.

Зайн цэнэгийн түвшнийг шалгах

Чихэвчийг мобайл төхөөрөмжтэйгөө холбоод мобайл төхөөрөмж дээрх **Galaxy Wearable** хэрэглүүрийг нээгээд, чихэвч, цэнэглэх хайрцгийн зайн төлөвийг шалгана. Дэлгэрэнгүй мэдээллийг [Утасгүй чихэвчийг мобайл төхөөрөмжид холбох](#)-ээс авна уу.



Зайн үлдэж буй цэнэг бага бол таны мобайл төхөөрөмжийн мэдэгдлийн самбарт мэдэгдэл харуулна.

Зайны хэрэглээг багасгах

Утасгүй чихэвчийг хэрэглээгүй үедээ цэнэгтэй цэнэглэх хайрцагт хадгал. Үгүй бол товшилт мэдрэгч үргэлжлүүлэн ажиллах бөгөөд энэ нь ашиглалтын хугацаа болон зайн зарцуулалтад нөлөөлнө.

Зайг цэнэглэх заавар болон санамжууд



Зөвхөн Galaxy Buds-д тусгайлан зориулсан Samsung-с зөвшөөрсөн цэнэглэгч болон кабелийг ашиглана уу. Тохирохгүй цэнэглэгч болон кабель таны төхөөрөмжийг гэмтээж болно.



- Цэнэглэгчийг буруу холбовол цэнэглэх хайрцагт ноцтой гэмтэл учирч болзошгүй. Буруу хэрэглээнээс болсон эвдрэл баталгаанд хамрагдахгүй.
- Зөвхөн Galaxy Buds-тай цуг ирсэн USB Type-C кабелийг хэрэглэ. Хэрэв бичил USB кабелийг хэрэглэвэл цэнэглэх хайрцгийг гэмтэж болзошгүй.
- Цэнэглэгчийн порт чийгтэй байхад Galaxy Buds-ийг цэнэглэвэл Galaxy Buds гэмтэж болзошгүй. Galaxy Buds-ийг цэнэглэхийн өмнө цэнэглэх портыг бүрэн хатаа.



- Цэнэглэгчийг тусад нь худалдана.
- Эрчим хүч хэмнэхийн тулд хэрэглээгүй үедээ цэнэглэгчийг салгаж бай. Цэнэглэгчинд унтраалга байхгүй тул хэрэглээгүй үедээ тог үрэхгүйн тулд та салгаж байх хэрэгтэй.
- Цэнэглэгч ашиглахдаа цэнэглэх үзүүлэлтийг батлах батлагдсан цэнэглэгч ашиглахыг зөвлөж байна.
- Утасгүй чихэвчийг хадгалах юм уу цэнэглэх, эсвэл цэнэглэх хайрцгийг цэнэглэх үедээ цэнэглэгч хайрцгийг хаалттай байлгана.
- Хэрэв цэнэглэх хайрцгийг цэнэглэж байхад цэнэглэх холболтод хүрвэл цэнэглэх явцад нөлөөлж болзошгүй.
- Хэрэв цэнэглэх холболт шингэн, хөлсөнд норсон бол Galaxy Buds зэвэрч болзошгүй. Цэнэглэх холболт эсвэл утасгүй чихэвч шингэн, хөлсөнд норсон бол утасгүй чихэвчийг цэнэглэх хайрцагт хийхийн өмнө цэвэрлэ.
- Та чихэвчээ цэнэглэх хайрцагт хийсэн тохиолдолд цэнэглэх ажиллагаа автоматаар эхлэх бөгөөд чихэвч бүрэн цэнэглэгдсэн тохиолдолд автоматаар зогсох болно.
- Чихэвч бүрэн цэнэглэгдсэний дараа та чихэвчээ цэнэглэх хайрцаас салгаагүй байсан ч энэ нь таны Galaxy Buds-ийн ашиглалтын хугацаанд тийм ч их нөлөө үзүүлэхгүй байх магадлалтай.
- Хэрэв та Galaxy Buds-ийг удаан хугацаагаар ашиглахгүй бол тэдгээрийг цэнэглэсний дараа хадгалаарай.
- Компьютер зэрэг цэнэглэгчээс өөр эрчим хүчний бага урсгалд залгаж цэнэглэвэл цэнэглэх хурд удааширч болно.
- Цэнэглэж байх үед Galaxy Buds болон цэнэглэгч халж болзошгүй. Энэ нь хэвийн үзэгдэл бөгөөд Galaxy Buds-ийн эдэлгээний хугацаа эсвэл гүйцэтгэлд ямар нэг нөлөө үзүүлэхгүй. Хэрэв зай хэвийн бус хэт халбал цэнэглэгч цэнэглэхээ болиж болно.
- Хэрэв Galaxy Buds зөв цэнэглэгдэхгүй бол цэнэглэгч болон Galaxy Buds-ийг Samsung-ийн засвар үйлчилгээний төв эсвэл зөвшөөрөлтэй засвар үйлчилгээний төвд аваачиж өгнө үү.
- USB кабелийг бүү нугал. Ингэснээр USB кабелийг гэмтээх юм уу ашиглах хугацааг бууруулна. Гэмтсэн USB кабелийг бүү ашигла.


Заагч гэрлийн тодорхойлох утга

Блэйд гэрэл болон цэнэглэх хайрцгийн зайн заагч гэрэл нь таны чихэвч болон цэнэглэх хайрцгийн төлөвийг харуулдаг.

Блэйд гэрэл (Galaxy Buds3 Pro)

Чихэвчийн төлөвийг шалгах

Та блэйд гэрлээр чихэвчийн төлөвийг шалгаж болно.



Үйлдэл	Төлөв
Нэг удаа анивчдаг	Цэнэглэх хайрцгийг нээх, чихэвчийг цэнэглэх хайрцагт хийж, хаах үед
Тасралтгүй асаалттай	Bluetooth хослуулах горимд ороход, чихэвч олдох үед



Хэрэв та бүрэн цэнэглэсэн утасгүй чихэвчийг цэнэглэх хайрцагт оруулаад түүнийг хурдан нээж хаавал эсвэл утасгүй чихэвч оруулсан цэнэглэх хайрцгийг алгуурхан хаавал, зөвхөн нэг утасгүй чихэвчний блэйд гэрэл асна.

Блэйд гэрэл ашиглах

Та хүссэн үедээ блэйд гэрлийг асааж, гэрэлтүүлгийн хэв маягийг өөрчлөх боломжтой.



- Энэ функц нь хоёр чихэвчийн зайн цэнэг хамгийн багадаа 30% байх үед л боломжтой.
- Энэ онцлогийг ашиглах нь утасгүй чихэвчний зайн зарцуулалтыг нэмэгдүүлнэ.

- 1 Мобайл төхөөрөмж дээрх **Galaxy Wearable** хэрэглүүрийг нээгээд **Чихэвчний удирдлагууд** → **Чихэвчийн гэрлийн удирдлага** дээр товш.

2 Гэрэлтүүлгийн хэв маягийг сонгох гэдгийн доор блэйд гэрлийн хүссэн гэрэлтүүлгийн загварыг сонго.

- **Анивчих:** блэйд гэрэл анивчих болно.
- **Аажмаар тодорч, бүдгэрэх:** Блэйд гэрлүүд аажмаар асаж, бүдгэрнэ.
- **Тогтвортой:** Блэйд гэрэл асаалттай байх болно.

Хэрэв та хоёр чихэвчийг зүүгээгүй байхдаа чимхээд барьвал сонгосон гэрэлтүүлгийн загвар чихэвч дээр харагдана.

Блэйд гэрлийг унтраахын тулд хоёр чихэвчийг зүүгээгүй байхдаа чимхээд барьж эсвэл цэнэглэх хайрцагт хийнэ. Та мөн мобайл төхөөрөмж дээрээ мэдэгдлийн самбарыг нээж болно, **Чихэвчний гэрэл асаалттай** мэдэгдэл дээрх  дээр товшоод, **Унтраах** дээр товш.

Цэнэглэх хайрцгийн зайн заагч гэрэл

Цэнэглэх хайрцгийн цэнэгийн төлөвийг цэнэглэх хайрцгийн зайн заагч гэрлийн өнгөөр шалгаарай.

Цэнэглэгчийн хайрцгийн доод хэсэгт байрлах Холбогдох товчийг богино хугацаанд дарах эсвэл цэнэглэх хайрцгийг нээх, хаах үед цэнэглэх хайрцгийн зайн заагч гэрэл гарч ирнэ.



Өнгө	Төлөв
Улаанаар асах	Утасгүй чихэвч (хэрэв тавьсан бол) болон цэнэглэх хайрцаг нь цэнэглэгдэж байна.
Ногооноор асах	Утасгүй чихэвч (хэрэв тавьсан бол) болон цэнэглэх хайрцаг нь бүрэн цэнэглэгдлээ.
Улаанаар анивчих	Цэнэглэж болохгүй болсон (утасгүй чихэвч эсвэл цэнэглэх хайрцгийн хэвийн бус температур, ус, хөлс, утасгүй чихэвч эсвэл цэнэглэх хайрцгийн цэнэглэх холболтууд дээр байгаа гадны материал)
Улаан анивчих (цэнэглэх хайрцгийг хаасны дараа анивчина)	Цэнэглэх хайрцгийн цэнэг багассан (10%-иас бага).

Өнгө	Төлөв
Улаан (цэнэглэх хайрцгийг хаасны дараа 5 секунд асна)	Цэнэглэх хайрцгийн цэнэг багассан (10%-иас 29%-ийн хооронд байна), утасгүй чихэвч цэнэглэгдэж байна.
Шар (цэнэглэх хайрцгийг хаасны дараа 5 секунд асна)	Цэнэглэх хайрцгийн цэнэг дунд зэрэг (30%-иас 59%-ийн хооронд байна).
Ногоон (цэнэглэх хайрцгийг хаасны дараа 5 секунд асна)	Цэнэглэх хайрцгийн цэнэг сайн (60%-иас их байна), утасгүй чихэвч бүрэн цэнэглэгдлээ.



- Хэрэв цэнэглэх хайрцгийн зайн заагч гэрэл нь тодорхойлсноор ажиллахгүй байвал цэнэглэгчийг цэнэглэх хайрцгаас салгаад дахин залгана уу.
- Утасгүй чихэвч эсвэл цэнэглэх хайрцгийн цэнэглэх холболт дээр ус, хөлс, гадны материалын улмаас цэнэглэж болохгүй байвал утасгүй чихэвч эсвэл цэнэглэх хайрцгийн цэнэглэх холболтыг цэвэрлээд дахин цэнэглэж үзнэ үү.

Чихэвч хэрэглэх

Утасгүй чихэвчийг мобайл төхөөрөмжид холбох

Холбохын өмнө

- Цэнэглэх хайрцгийн хангалттай цэнэглэ.
- Таны мобайл төхөөрөмж дээр Galaxy Wearable хэрэглүүр суурилсан байх ёстой. Хэрэв таны мобайл төхөөрөмж дээр хэрэглүүр суурилаагүй бол **Galaxy Store** эсвэл **Play Store**-оос хэрэглүүрийг татаж авна уу.
-  • Зөвхөн Android OS хувилбар 10.0 (API 26) буюу түүнээс хойших хувилбартай, 1,5 Гбайт ба түүнээс дээш хадгалах зай бүхий мобайл төхөөрөмж дээр Galaxy Wearable хэрэглүүрийг татаж авч болно.
- Та өөрийн мобайл төхөөрөмж дээрээ Galaxy Wearable хэрэглүүрийн хэлийг өөрчилж болно. Мобайл төхөөрөмж дээрээ **Тохиргоо**-г нээж **Ерөнхий удирдлага** → **Хэл** дээр товшино уу. Тохиргоон дээр сонгосон хэл Galaxy Wearable хэрэглүүрт дэмжигдэхгүй байвал англи хэл өгөгдмөлөөр сонгогдсон байж болно.
- Android үйлдлийн системийн 16 буюу түүнээс дээш хувилбарыг ажиллуулж байгаа мобайл төхөөрөмжүүд дээр та чихэвчийг Тохиргооны дэлгэцээс холбож болно.

Чихэвчийг Samsung мобайл төхөөрөмжтэй анх удаа холбох

- 1 Чихэвч бүрийн чиглэлийг шалгаж, цэнэглэх хайрцгийн харгалзах үүрэнд зөв байрлуулна.

Хэрэв цэнэглэх хайрцгийн зайн заагч гэрэл анивчихгүй байвал цэнэглэх хайрцгийг цэнэглэгчид залгаад 10 минутаас дээш хугацаагаар цэнэглэ.

2 Цэнэглэх хайрцгийг хаагаад нээ.

Эсвэл цэнэглэх хайрцгийг нээгээд, цэнэглэх хайрцгийн доод хэсэгт байрлах Холбогдох товчийг 3 секундээс дээш хугацаанд дар.

Утасгүй чихэвч автоматаар Bluetooth хослуулах горимд орох ба мобайл төхөөрөмж дээр попап цонх гарч ирнэ.


Хэрэв попап цонх гарч ирэхгүй эсвэл та Samsung-ийн бус Android OS үйлдлийн систем бүхий мобайл төхөөрөмжтэй холбох гэж байгаа бол үүнийг үзнэ үү: [Чихэвчийг Android OS үйлдлийн систем бүхий Samsung-ийн бус мобайл төхөөрөмжтэй холбогдох \(эсвэл холболтын попап цонх гарч ирэхгүй байх\).](#)



Цэнэглэх хайрцгийн зайн заагч гэрэл улаанаар анивчиж байгаа бол чихэвчийг цэнэглэх хайрцгаас гаргаад, хайрцаг руу буцааж хий.


3 Мобайл төхөөрөмж дээрх попап цонхонд буй **Холбогд** дээр товшоод зааврыг дагаж холболтыг гүйцэтгэнэ.

Холболт хийгдсэний дараа чихэвч дотор нь байх үед цэнэглэх хайрцгийг онгойлгох бүрт чихэвч нь таны мобайл төхөөрөмжид автоматаар холбогдох болно.





- Зөвхөн Android OS хувилбар 10.0 (API 26) буюу түүнээс хойших хувилбартай, 1,5 Гбайт ба түүнээс дээш хадгалах зай бүхий мобайл төхөөрөмж дээр Galaxy Wearable хэрэглүүрийг татаж авч болно.
- Таны төхөөрөмж болон программ хангамжийн хувилбараас хамаарч холболтын аргууд нь харилцан адилгүй байж болно.
- Попап цонхны харагдах байдал нь таны холбогдсон мобайл төхөөрөмжөөс хамаарч өөр өөр байж болно.
- Хэрэв утасгүй чихэвч мобайл төхөөрөмжтэй 3 минутын дотор холбогдохгүй бол Bluetooth хослуулах горим унтарна. Цэнэглэх хайрцгийг дахин хаагаад нээ. Утасгүй чихэвч Bluetooth хослуулах горимд орно.
- Хэрэв та холболт тохируулсаны дараа өөр мобайл төхөөрөмжтэй холбогдохыг хүсвэл **Өмнөх мобайл төхөөрөмжөөс салгасны дараа бусад төхөөрөмжтэй холбох**-с үзнэ үү.
- Samsung бүртгэлд нэвтэрсэн мобайл төхөөрөмжтэй чихэвчийг холбох үед уг Samsung бүртгэлийг ашигладаг өөр мобайл төхөөрөмж дээр чихэвчийн холболтын мэдээллийг синхрончилж хадгалах тул тэдгээрийг эхний удаад дахин холбох хэрэг гарахгүй. Тухайн Samsung бүртгэлийг ашигладаг бусад төхөөрөмжийг чихэвчтэй холбохдоо мэдэгдлийн самбарыг нээгээд **Тохиргоо** нээгээд **Холболтууд** → **Bluetooth** дээр товшоод Samsung бүртгэлээр синхрончилсон чихэвчийг сонго.
- Өрөөсөн чихэвч таны мобайл төхөөрөмжтэй холбогдсон бол моно дуу сонсогдоно. Мобайл төхөөрөмжид хос чихэвч холбогдмогц автоматаар Стерео горимд шилжинэ.
- Хэрэв утасгүй чихэвч нь мобайл төхөөрөмжид холбогдоогүй, попап цонх гарч ирэхгүй, эсвэл таны мобайл төхөөрөмж чихэвчийг олж чадахгүй байвал чихэвчээ цэнэглэх хайрцагт байлгаад Холбогдох товчийг 3 секундээс дээш хугацаанд дарж Bluetooth хослуулах горимыг гараар оруул. Bluetooth хослуулах горимыг оруулсны дараа цэнэглэх хайрцгийн зайн заагч гэрэл улаан, ногоон, цэнхэр өнгөөр анивчих болно. Загвараас хамааран блэйд гэрлүүд анивчдаг.



Чихэвчийг Android OS үйлдлийн систем бүхий Samsung-ийн бус мобайл төхөөрөмжтэй холбогдох (эсвэл холболтын попап цонх гарч ирэхгүй байх)



Хэрэв та Android OS үйлдлийн систем ашигладаг Samsung биш мобайл төхөөрөмжид холбогдвол чихэвчний зарим онцлог шинж чанарууд ашиглах боломжгүй, чихэвч зөв ажиллахгүй байж магадгүй юм.

- 1 Чихэвч бүрийн чиглэлийг шалгаж, цэнэглэх хайрцгийн харгалзах үүрэнд зөв байрлуулна.
Хэрэв цэнэглэх хайрцгийн зайн заагч гэрэл анивчихгүй байвал цэнэглэх хайрцгийг цэнэглэгчид залгаад 10 минутаас дээш хугацаагар цэнэглэ.
- 2 Цэнэглэх хайрцгийг хаагаад нээ.
Эсвэл цэнэглэх хайрцгийг нээгээд, цэнэглэх хайрцгийн доод хэсэгт байрлах Холбогдох товчийг 3 секундээс дээш хугацаанд дар.
Утасгүй чихэвч Bluetooth хослуулах горимд орно.
- 3 Мобайл төхөөрөмж дээрээ Bluetooth функцийг асааж утасгүй чихэвчийг мобайл төхөөрөмжтэй холбохын тулд **Galaxy Wearable** хэрэглүүрийг нээгээд дэлгэц дээрх зааврыг дагаж холболтыг гүйцэтгэнэ.



Android үйлдлийн системийн 16 буюу түүнээс дээш хувилбарыг ажиллуулж байгаа мобайл төхөөрөмжүүд дээр та чихэвчийг Тохиргооны дэлгэцээс холбож болно.



Bluetooth ашиглахад анхаарах зүйлс

- Чихэвчийг өөр төхөөрөмжтэй холбоход үүсэхэд бэрхшээл гарахаас сэргийлэхийн тулд төхөөрөмжүүдийг ойр зайтай байрлуулна.
- Чихэвч болон нөгөө Bluetooth төхөөрөмжүүд Bluetooth-ийн холболтын хязгаар дотор (10 м) байвал зохино. Төхөөрөмжийг хэрэглэж буй орчны нөхцөлөөс хамааран зай янз бүр байна.
- Чихэвч ба холбогдсон төхөөрөмжийн хооронд хүний бие, хана, булан, хашаа зэрэг саад болох зүйлс байж болохгүй.
- Холбогдсон төхөөрөмжийн Bluetooth антенд хүрч болохгүй.
- Bluetooth нь шинжлэх ухааны, эмчилгээний зориулалттай, бага чадлын бүтээгдэхүүний нэгэн адил давтамж ашигладаг тул ийм төрлийн бүтээгдэхүүний ойр хэрэглэвэл интерференц үүсэж болно.
- Зарим төхөөрөмж, ялангуяа Bluetooth SIG-ээр шалгуулж, баталгаажгаагүй бол таны чихэвчтэй нийцэж ажиллахгүй байж болзошгүй.
- Bluetooth-ийг хууль бус зориулалтаар (тухайлбал, хулгайгаар хуулбарлах, арилжааны зорилготой харилцааг хууль бусаар тандах) бүү ашигла.

Сүлжээ ашиглах

Та Bluetooth зэрэг сүлжээг ашиглах боломжтой.

Холбосон гар утасны төхөөрөмж дээрх **Тохиргоо** гэснийг нээгээд **Холболтууд** товшиж, дараа нь **Bluetooth** сэлгүүрийг товшиж асаана уу.

Сүлжээг ашиглаагүй үед сэлгүүрийг товшиж үүнийг унтраана уу.



Загвараас хамаараад зарим онцлогийг ашиглах боломжгүй байж магадгүй.


Утасгүй чихэвч зүүх

Чихэвчийг чихэндээ тааруулан хийнэ.




- Хэрэв товшилт мэдрэгч таны чихэнд хүрэлцэхгүй бол чихэвч ажиллахгүй байж болзошгүй. Хэрэв та чихэвчийг таньсан гэсэн дууг сонсохгүй байвал чихэвчийг чихнээсээ аваад буцааж хий эсвэл чихэндээ таарсан зөөлөвч рүү шилжүүлээрэй.
- Чихэвчийн шинж чанараас шалтгаалан чихэвч зүүсэн үед сул байх эсвэл чихнээс чинь салсан байж болзошгүй. (Galaxy Buds3)
- Хэрэв утасгүй чихэвчийг чихэнд зөв байрлуулаагүй бол чихэвчээр залгах гэх мэт функцүүд ажиллахгүй байж болзошгүй. Чихэндээ тохирсон хос зөөлөвч хэрэглэн утасгүй чихэвчийг тааруулан зүүнэ. (Galaxy Buds3 Pro)
- Онгоц, эмнэлэг гэх мэт утасгүй төхөөрөмжийг ашиглахыг хязгаарласан газарт эрх бүхий ажилтнуудаас ирүүлсэн бүх анхааруулга, зааврыг дагана уу.

1 Чихэвч бүрийг бариад, цэнэглэх хайрцгаас босоогоор нь салгаж ав.




- 2 Чихэвч тус бүрийн чиглэлийг шалгана уу.
- 3 Утасгүй чихэвчийг тань руу харсан чигийн тэмдгийн дагуу чихэндээ хийж, чихэвчийн доод хэсэгт байрлах микрофоныг ам руугаа чиглүүлнэ.
- 4 Чихэвчийг зүүн эсвэл баруун тийш эргүүлснээр чихэнд тань тухтай таарна.
Чихэвчийг зүүмэгц товшилт мэдрэгчүүд зүүсэн эсэхийг илрүүлнэ. Дараа нь чихэвчийг таньсан тухай дуу танд сонсогдоно.



Утасгүй чихэвчийг дохиогоор хэрэглэх


Танилцуулга

Чихэвчийг хавчаад эсвэл гүйлгээд хөгжим тоглуулж, зогсоож эсвэл дуудлагад хариулж, дуудлагаас татгалзаж болно. Та хавчих юм уу гүйлгээд өөр үйлдэл гүйцэтгэхээр чихэвчийг тохируулж болно. Дараах нэр томьёо, дохио зангаа нь хавчих хэсэг болон гүйлгэх хэсгийг хоёуланг нь агуулна.



- Чихээ өвтгөхгүйн тулд чихэвчийг хэт чанга дарахаас сэргийл.
- Дохио зангааны хэсгийг гэмтээхгүй тулд чихэвчийг ямар нэгэн үзүүртэй зүйлээр хавчих юм уу гүйлгэж болохгүй.
- Хэрэв таны чихэнд ээмэг гэх мэт металл зүйл байвал түүнийг аваарай. Хэрэв утасгүй чихэвчтэй металл зүйл шүргэлцвэл чихэвчийн дохио зангааны функц доголдож эсвэл хариу өгөхгүй байж болзошгүй.
- Хэрэв утасгүй чихэвч дээр хөлс, шингэн байвал цэвэрлэнэ үү. Чихэвчийн дохио зангааны функц нь хөлс, шингэний улмаас ажиллахгүй эсвэл хариу өгөхгүй байж болзошгүй.
- Утасгүй чихэвчийг чихнээсээ авсны дараа болгоомжтой байж дохио зангааны хэсгүүдийг хавчиж, гүйлгэж болохгүй. Эс бөгөөс санамсаргүйгээр онцлогуудыг ажиллуулж болзошгүй.

Дохио зангааг ойлгох



Ганц хавчих

- Дуу тоглуулж, түр зогсооно.
- Дуудлагад хариулж, дуусгана.
- Мэдэгдлийг чангаар унших функцийг ашиглахаа зогсооно уу.
- Дуу таних эсвэл Дуут дохио илрүүлэх функцийг ашиглахаа зогсооно уу.



Давхар хавчих

- Дараагийн дууг тоглуулна.



Гурав хавчих

- Өмнөх дууг тоглуулна.
 - Дуу тоглуулж эхэлснээс хойш 3 секундйн дараа гурван удаа чихэвчийг хавчвал тухайн дууг эхнээс нь тоглуулна. Дууны эхний 3 секундйн дотор чихэвчийг гурав хавчвал өмнөх дууг тоглуулна.



Хавчаад барих

- Урьчилан тохируулах онцлогийг асаана.
 - Энэ нь Дуу чимээг хянах горимыг асаахаар өгөгдмөлөөр тохируулагдсан байна. Та асаахыг хүссэн онцлогийг өөрчлөх талаар нэмэлт мэдээлэл авах бол [Хавчаад барих функцийг тохируулах](#)-с харна уу.
- Дуудлагаас татгалзана.
- Чихэвч зүүгээгүй үедээ хоёр чихэвчийг хавчиж бариад блэйд гэрлийг асаана. (Galaxy Buds3 Pro)



Дээш эсвэл доош шударна

- Дууг чангалах, сулла.



Хэрэв утасгүй чихэвч нь мобайл төхөөрөмжид холбогдоогүй, попап цонх гарч ирэхгүй, эсвэл таны мобайл төхөөрөмж чихэвчийг олж чадахгүй байвал чихэвчээ цэнэглэх хайрцагт байлгаад Холбогдох товчийг 3 секундээс дээш хугацаанд дарж Bluetooth хослуулах горимыг гараар оруул. Bluetooth хослуулах горимыг оруулсны дараа цэнэглэх хайрцгийн зайн заагч гэрэл улаан, ногоон, цэнхэр өнгөөр анивчих болно. Загвараас хамааран блэйд гэрлүүд анивчдаг.

Хавчаад барих функцийг тохируулах

Та функцүүдийг асаахын тулд чихэвч тус бүр дээр хавчаад барих функцийг тохируулж болно.

- 1 Мобайл төхөөрөмж дээрээ **Galaxy Wearable** хэрэглүүрийг нээгээд **Чихэвчний удирдлагууд** дээр товш.
- 2 Зүүн эсвэл **Баруун** сэлгүүрийг **Удирдлагуудыг чимхээд барих** гэдгийн доороос товшиж, үүнийг асаана.
- 3 Чихэвч бүрийн хавчаад барих функцийг сонгоно.
 - **Дуу чимээний хяналтыг солих:** Дараах дуу чимээг хянах горимуудыг асаах эсвэл унтраахаар тохируулна: Орчны дуу, Дасан зохицох, Идэвхтэй дуу чимээг арилгах. Дэлгэрэнгүй мэдээллийг [Дуу чимээний хяналтын горимуудыг идэвхжүүлэх](#)-ээс авна уу.
 - **Bixby:** Ухаалаг дуут туслах үйлчилгээтэй яриа эхэлнэ. Bixby ашиглахдаа нэмэлт мэдээллийг [Bixby-г ашиглах](#)-с үзнэ үү.
 - **Орчуулагч:** Ярианы харилцан яриаг шууд орчуулж, яриа эсвэл текст болгон гаргана.
 - **Бясалгал:** Оюуны төвлөрлийн хөгжим тоглуулна. Та мөн Samsung Health хэрэглүүрээс тоглуулах жагсаалтыг шалгаж болно.



Холбогдсон мобайл төхөөрөмжөөс хамааран боломжит сонголтууд өөр байж болно.

Дуу чимээний хяналтын горимуудыг ашиглах

Танилцуулга

► **Galaxy Buds3:** Таны эргэн тойрны дуу чимээг бууруулахын тулд Идэвхтэй дуу чимээг арилгах функцийг асаана. Хөгжим сонсох үед анхаарал сарниулах зэргээс зайлсхийхийг хүссэн үедээ үүнийг ашиглана уу.

► **Galaxy Buds3 Pro:** Дуу чимээг хянах гурван горим байдаг: Орчны дуу, Дасан зохицох, Идэвхтэй дуу чимээг арилгах.

Хүрээлэн буй орчноо тодорхой сонсохын тулд Орчны дууны горимыг асаагаарай, ингэснээр та болзошгүй аюултай нөхцөл байдлыг илрүүлж эсвэл харилцан ярианы явцад өөр хүний дуу хоолойг сонсох боломжтой болно. Эргэн тойрны дуу чимээний хэмжээ эсвэл Идэвхтэй дуу чимээг эргэн тойрны дуу чимээний хэмжээний дагуу автоматаар арилгах хүчийг оновчтой болгохын тулд Дасан зохицох горимыг асаа. Дуу чимээг арилгах функц нь чимээ шуугиантай газар ажилладаг боловч чимээгүй үед чихэвч нь орчны дуу чимээг нэвтрүүлэх болно. Таны эргэн тойрны дуу чимээг бууруулахын тулд Идэвхтэй дуу чимээг арилгах функцийг асаана. Хөгжим сонсох үед анхаарал сарниулах зэргээс зайлсхийхийг хүссэн үедээ үүнийг ашиглана уу.



Хэрэв микрофон (утасгүй чихэвчийг зүүж байх үед гаднах микрофон) ба түүний хэсэг бүрэн бүрхэгдсэн бол дуу чимээ хянах горимыг идэвхжүүлэхэд санал хүсэлт гарч болзошгүй.



Та зөвхөн хоёр чихэвчээ зүүсэн үед л Дасан зохицох горим болон Идэвхтэй дуу чимээг арилгах функцийг асаах боломжтой.

Дуу чимээний хяналтын горимуудыг идэвхжүүлэх

Чихэвчнээс идэвхжүүлж байна

Хавчаад барих онцлогийг **Дуу чимээний хяналтыг солих** руу тохируулсан эсэхээ шалгаад, утасгүй чихэвчийг хавчаад барина уу.

► **Galaxy Buds3:** Идэвхтэй дуу чимээг арилгах функцийг эхлүүлэх болно.

► **Galaxy Buds3 Pro:** Дараах дуу чимээний хяналтын горимуудыг ажиллуулна: Орчны дуу, Дасан зохицох, Идэвхтэй дуу чимээг арилгах.



Хэрэв хавчаад барих функцийг **Дуу чимээний хяналтыг солих** гэж тохируулсан бөгөөд Унтраах сонголтыг агуулж байвал дуу чимээний хяналтын горимууд унтарч болзошгүй. **Дуу чимээний хяналтыг солих** дээр товшоод сонгосон сонголтоо шалгана уу.

Galaxy Wearable хэрэглүүрээс идэвхжүүлж байна

- ▶ Galaxy Buds3: Мобайл төхөөрөмж дээрээ **Galaxy Wearable** хэрэглүүрийг нээгээд, **Идэвхтэй дуу чимээг цуцлах** сэлгүүр дээр товшиж үүнийг асаана.
- ▶ Galaxy Buds3 Pro: мобайл төхөөрөмж дээрээ **Galaxy Wearable** хэрэглүүрийг нээгээд, **Орчны дуу, Тааруулж болох**, эсвэл **Идэвхтэй дуу чимээг цуцлах** дээр товш.

Тохиргооноос идэвхжүүлэх



- Энэ функцийг зөвхөн Android 11 One UI хувилбар 3.1 ба түүнээс дээш хувилбарыг ажиллуулж буй мобайл төхөөрөмж дээр ашиглах боломжтой.
- Холбогдсон мобайл төхөөрөмжөөс хамааран боломжит сонголтууд өөр байж болно.

- 1 Мобайл төхөөрөмж дээрээ **Тохиргоо**-г нээж **Холболтууд** → **Bluetooth** дээр товшино уу.
- 2 **Хослогдсон төхөөрөмжүүд** дор чихэвчний нэрний хажууд -ийг товшино уу.
- 3 ▶ Galaxy Buds3: **Идэвхтэй дуу чимээг цуцлах** сэлгүүр дээр товшоод үүнийг асаана.
▶ Galaxy Buds3 Pro: **Орчны дуу, Тааруулж болох**, эсвэл **Идэвхтэй дуу чимээг цуцлах** дээр товш.

Виджетээс идэвхжүүлж байна

- ▶ Galaxy Buds3: Galaxy Buds удирдлагын виджетийг мобайл төхөөрөмжид нэмээд, **Идэвхтэй дуу чимээг цуцлах** дээр товш.
- ▶ Galaxy Buds3 Pro: Galaxy Buds удирдлагын виджетийг мобайл төхөөрөмжид нэмээд, хүссэн дуу чимээний хяналтын дүрс дээр товш.

Дуу чимээний хяналтын эрчмийг тохируулах (Galaxy Buds3 Pro)

Орчны дуу эсвэл Идэвхтэй дуу чимээг арилгах функцийг дуу чимээг хянах горим болгон асаасан үед эргэн тойрны дуу чимээний хэмжээ эсвэл Идэвхтэй дуу чимээг арилгах хүчийг өөрийн сонголтод нийцүүлэн тохируулна уу.

- 1 Мобайл төхөөрөмж дээрээ **Galaxy Wearable** хэрэглүүрийг нээгээд, **Орчны дуу** эсвэл **Идэвхтэй дуу чимээг цуцлах** дээр товшино.
- 2 **Орчны дууны түвшин** эсвэл **Идэвхтэй дууг цуцлах түвшин** гэсний доор тохируулах самбарыг чирнэ.



- Хэрэв та хүртээмжийн тохиргооны Орчны дууны сонсголын сайжруулалтын функцийг ашиглаж байгаа бол тохиргоог шалгахын тулд **Сонсголын сайжруулалтыг ашиглаж байна** дээр товшино уу.

Орчны дуу руу автоматаар шилжих (Galaxy Buds3 Pro)

Утасгүй чихэвч зүүж байхдаа харилцан ярих, утсаар ярих зэрэг тодорхой нөхцөл байдалд чихэвч нь үүнийг илрүүлж, Орчны дууны горимыг автоматаар асаах бөгөөд энэ нь таныг эргэн тойрны нөхцөл байдал эсвэл харилцан ярианд анхаарлаа төвлөрүүлэх боломжийг олгоно.

1 Мобайл төхөөрөмж дээрээ **Galaxy Wearable** хэрэглүүрийг нээгээд, **Орчны дуу чимээ рүү автоматаар шилжих** дээр товш.

2 Чихэвчийг Орчны дууны горимыг автоматаар асаалгахыг хүссэн нөхцөл байдлын сэлгүүрийг товш.

- **Дуу хоолой илрүүлэх:** Хэрэв та утасгүй чихэвч зүүж байхдаа ярьж эхэлбэл чихэвч таны дуу хоолойг ямар ч нөхцөлд таньж, Орчны дууны горимыг асаана. Хэрэв тодорхой хугацаанд харилцан яриа илрээгүй бол Орчны дууны горим унтарна.



- Хоёр чихэвчийн дуу хоолой таних мэдрэгч нь тэдгээрийг ашиглаж байх үед таны дуу хоолойг илрүүлдэг. Тиймээс, хэрэв та зөвхөн нэг чихэндээ чихэвч зүүсэн бол энэ функц нь ашиглах боломжтой байж магадгүй.
- Шүдээ угаах, ханиалгах, дуугарах гэх мэт чимээ гаргах үед чихэвч үүнийг яриа гэж буруугаар тайлбарлаж болно.
- Дуу хоолойг удирдах функцийг асаасан үед чихэвч дуу хоолойг илрүүлсэн ч Орчны дууны горим нь дуут удирдлагын команд мөн эсэхийг олж мэдсэний дараа л асах тул хэсэг хугацаа болсны дараа хариу үйлдэл үзүүлж болзошгүй.
- **Дохио илрүүлэх:** Чихэвч нь тодорхой түвшнээс дээш дуут дохиог илрүүлж, Орчны дууны горимыг асаана.
- **Дуудлагн үед Орчны дуу ашиглах:** Чихэвч нь дуудлагын үеэр таны дууг сонсогддог болгож, санамсаргүйгээр дуугаа өндөрсгөхөөс сэргийлж, урт дуудлагыг илүү таатай болгоход тусална.

Орчны дууны горим автоматаар идэвхэжсэн үед чихэвчийг нэг удаа хавчиж унтраана.

Дуу хөгжим сонсох

Чихэвчийг мобайл төхөөрөмжтэй холбоод мобайл төхөөрөмж дээр хадгалсан дуу хөгжмийг сонсоно. Мөн та холбогдсон мобайл төхөөрөмж дээр тоглуулж байгаа дуу хөгжмийг нэвтрүүлж болно.

Мобайл төхөөрөмж дээрээ хөгжим тоглуулагчийг нээгээд дуу хөгжмөө тоглуул.

Дуу тоглуулж, түр зогсоох

Чихэвчийг хавчаад дууг тоглуулах эсвэл түр зогсооно.

Дараагийн дууг тоглуулах

Чихэвчийг давхар хавчаад дараагийн дууг тоглуулна.

Өмнөх дууг тоглуулах

Чихэвчийг гурав хавчаад өмнөх дууг тоглуулна.



Дуу тоглуулж эхэлснээс хойш 3 секундийн дараа гурван удаа чихэвчийг хавчвал тухайн дууг эхнээс нь тоглуулна. Дууны эхний 3 секундийн дотор чихэвчийг гурав хавчвал өмнөх дууг тоглуулна.

Дуу чангалах, суллах

Дууг нэмэгдүүлэхийн тулд чихэвчийг дээш шудар, эсвэл дууг багасгахын тулд чихэвчийг доош шударна.



- Утасгүй чихэвчийн дууны түвшин дээд хэмжээндээ байсан ч дуу сул байвал холбогдсон мобайл төхөөрөмжөөр дууны түвшнийг тааруул.
- Хэрэв хөгжим сонсохдоо утасгүй чихэвчийг мобайл төхөөрөмжид холбосон бол дууны түвшин өөрчлөгдөж болно.

Тэнцвэржүүлэгч ашиглах

Хэд хэдэн янзын жигдрүүлэгчийн сонголтоос сонгож нэг хөгжмийг өвөрмөц, өөр хөгөөр сонсож болно.

Мобайл төхөөрөмж дээрээ **Galaxy Wearable** хэрэглүүрийг нээгээд, **Дууны чанар ба эффектүүд** → **Тогтворжуулагч** дээр товшоод, дараа нь хүссэн сонголтоо сонгоно уу. Жигдрүүлэгчийг хүссэнээрээ тохируулахын тулд **Тусгай** гэдгийг сонго.

Дуудлагын функц хэрэглэх

Утасгүй чихэвчээ мобайл төхөөрөмжтэй холбож зүүсэн үедээ холбогдсон мобайл төхөөрөмжөөс дуудлагад хариулж, дуудлагыг удирдаж болно.



Хэрэв та дуут мэдэгдлээр дамжуулан ирж буй ирсэн дуудлагын утасны дугаар эсвэл харилцагч дотор хадгалагдсан нэрийн талаар мэдэгдэл аваагүй бол мобайл төхөөрөмж дээрээ **Утас** хэрэглүүрийг нээгээд **☰** → **Тохиргоо** → **Дуудлага хариулах ба таслах** гэснийг товшоод **Дуудагчийн нэрийг чангаар унших** сэлгүүрийг дарж асаана уу.

Дуудлагад хариулах буюу татгалзах

Таныг чихэвч зүүсэн үед дуудлага ирвэл чихэвч чимээ гаргаж, ирж буй дуудлагын утасны дугаарыг юм уу хадгалсан харилцагчийн нэрийг танд дуу хоолойгоор мэдээлнэ.

Дуудлагад хариулахдаа чихэвчийг хавч.

Дуудлагаас татгалзахдаа чихэвчийг хавчаад барь.

Дуудлага дуусгах

Тухайн дуудлагын таслахдаа чихэвчийг хавч.

Bixby

Танилцуулга

Bixby бол төхөөрөмжийг өөртөө эвтэйхэн ашиглахад туслах хэрэглэгчийн интерфейс юм.

Та Bixby-тэй ярих эсвэл текст бичих боломжтой. Bixby таны хүссэн функцийг холбогдсон мобайл төхөөрөмж дээр нээж, хүссэн мэдээллийг тань харуулна. www.samsung.com/bixby-д зочлоод нэмэлт мэдээлэл авна уу.



- Зөвхөн Bixby ашигладаг мобайл төхөөрөмж холбогдсон үед энэ функцийг ашиглах боломжтой.
- Мань мобайл төхөөрөмжид тохируулсан Bixby-гээс хамаараад зөвхөн зарим хэлээр ашиглах боломжтой. Танай бүс нутгаас хамаараад зарим функцийг ашиглах боломжгүй байж магадгүй.

Bixby-г эхлүүлэх

Хавчаад барих онцлогийг Bixby-г нээхээр тохируулсан эсэхээ шалгаад, утасгүй чихэвчийг хавчаад барь.

Bixby-г ашиглах

Чихэвчийг хавчаад барьж хүссэн зүйлээ хэлээрэй. Эсвэл сэрээх хэллэгийг хэлээд хүссэн зүйлээ хэлээрэй.

Жишээлбэл, чихэвчийг хавчаад барьж байхдаа "How's the weather today?" гэж хэлээрэй. Цаг агаарын мэдээлэл таны холбогдсон мобайл төхөөрөмж дээр гарч ирнэ.

Хэрэв ярианы үеэр Bixby танаас асуулт асуувал та чихэвчийг хавчаад барьж эсвэл -г товшихгүйгээр Bixby-тэй үргэлжлүүлэн ярих боломжтой.

Bixby таны дуу хоолойг ашиглан сэрж байна

Та Bixby-тай хийх яриагаа, чихэвч зүүсэн үедээ мобайл төхөөрөмж дээрээ тохируулсан сэрээх хэллэг ("Hi, Bixby" эсвэл "Bixby")-ийг хэлж эхлүүлэх боломжтой.

1 Мобайл төхөөрөмж дээрээ **Galaxy Wearable** хэрэглүүрийг нээгээд **Чихэвчийн тохиргоо** дээр товш.

2 **Дуут удирдлагууд** дээр товшоод, **Bixby дуут сэрээх** сэлгүүр дээр товшин үүнийг асаана.

Текст бичих замаар харилцах

Хэрэв та чимээ шуугиантай орчноос болж таны дуу хоолойг танихгүй эсвэл ярихад хэцүү байгаа бол Bixby-тай текстээр дамжуулан харилцах боломжтой.

Чихэвчийг хавчаад барьж,  дээр товшин хүссэн зүйлээ бичээрэй.

Харилцааны үеэр Bixby танд дуут санал хүсэлтийн оронд текстээр хариулах болно.

Илүү сайн дуу хоолой таниулалтын аргууд

- Цэвэрхэн ярина уу.
- Чимээгүй газарт ярина уу.
- Доромжилсон эсвэл этгээд үг бүү ашигла.
- Нутгийн аялгаар ярихаас зайлсхийнэ үү.

Таны байгаа орчноос эсвэл таны хэрхэн ярихаас хамааран Galaxy Buds таны хэлсэн тушаалыг ойлгохгүй эсвэл тушаалыг буруу биелүүлж болзошгүй.

Galaxy Wearable хэрэглүүр

Танилцуулга

Та Galaxy Buds-ийн үлдсэн зайг шалгаж, Galaxy Wearable хэрэглүүрийн тусламжтайгаар тохиргоог хийх боломжтой.


Мобайл төхөөрөмж дээрээ **Galaxy Wearable** хэрэглүүрийг нээ.

Түлхүүр үг оруулах замаар тохиргоо хайхын тулд **Q**-г товшино уу. Та мөн **Саналууд** хэсгээс шошгыг сонгон тохиргоо хайх боломжтой.

Galaxy Wearable хэрэглүүрийн тохиргоог тохируулахын тулд  →  дээр товшоод, **Тохиргоо** дээр товш.



- Galaxy Wearable хэрэглүүрийг ашиглахын тулд чихэвч нь мобайл төхөөрөмжид холбогдсон байх ёстой. Дэлгэрэнгүй мэдээллийг [Утасгүй чихэвчийг мобайл төхөөрөмжид холбох](#)-ээс авна уу.
- Холбогдсон мобайл төхөөрөмжийн төрөл эсвэл загвараас хамааран зарим функц ашиглах боломжгүй байж магадгүй.
- Android үйлдлийн системийн 16 буюу түүнээс дээш хувилбарыг ажиллуулж байгаа мобайл төхөөрөмж дээр чихэвчийг холбохдоо та Тохиргооны дэлгэцээс Galaxy Buds-н тохиргоог хийж болно.



Galaxy Buds-ийн үлдсэн зай

Galaxy Buds-ийн тохиргоог хийж, хүссэн функцээ ажиллуулна уу.

Төхөөрөмжийн холболтыг удирдах

Та мобайл төхөөрөмждөө холбогдсон зүүдэг төхөөрөмжөө шалгах эсвэл Galaxy Wearable хэрэглүүрт шинэ төхөөрөмж холбох гэх мэт төрөл бүрийн төхөөрөмжийн холболтыг удирдах боломжтой.

Холбогдсон төхөөрөмжүүдийг удирдах

Мобайл төхөөрөмжийнхөө Galaxy Wearable дэлгэц дээрх -г товш.

Жагсаалтад одоо холбогдсон болон өмнө нь холбогдсон төхөөрөмжүүд гарч ирнэ.



- Төхөөрөмжийг мобайл төхөөрөмжөөсөө салгахын тулд жагсаалтад холбогдсон төхөөрөмжийн хажууд байгаа -г товш.
- Өмнө нь холбогдсон төхөөрөмжтэйгөө дахин холбогдохын тулд жагсаалтаас холбогдохыг хүссэн төхөөрөмжөө сонгоно.

Шинэ төхөөрөмж нэмэх, төхөөрөмжийг устгах

1 Мобайл төхөөрөмжийнхөө Galaxy Wearable дэлгэц дээрх -г товш.

2 **+** дээр товшоод дэлгэц дээрх зааврыг даган шинэ зүүдэг төхөөрөмж холбоорой.

Шинэ зүүдэг төхөөрөмж холбогдож, жагсаалтад нэмэгдэнэ.

Жагсаалтаас зүүдэг төхөөрөмжийг устгахын тулд  → **Төхөөрөмж арилгах** дээр товшоод, төхөөрөмжийг сонгосны дараа **Арилгах** дээр товшино.



Таныг шинэ чихэвчтэй холбогдоход одоо холбогдсон чихэвч түр хугацаанд сална.

Чихэвчийг холбох, салгах

Мобайл төхөөрөмжийг чихэвчээс салгах

Чихэвчийг цэнэглэх хайрцагт хигээд тагла. Bluetooth холболт төгсөнө.

Чихэвчийг мобайл төхөөрөмжөөсөө салгахын тулд мобайл төхөөрөмж дээрээсээ **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд, **Холболтууд** → **Bluetooth** дээр товшиж, дараа нь мобайл төхөөрөмжийн **Хослогдсон төхөөрөмжүүд** чихэвчийг салгаарай.

Мобайл төхөөрөмжүүдийг түр зуур холболт салсан чихэвчтэй дахин холбох

Төхөөрөмжөөс түр хугацаанд холболт салсан чихэвчийг дахин холбохдоо цэнэглэх хайрцагт хийгээд тагийг тавина. Дараа нь цэнэглэх хайрцгийг нээнэ. Эсвэл цэнэглэх хайрцгийг нээгээд, цэнэглэх хайрцгийн доод хэсэгт байрлах Холбогдох товчийг 3 секундээс дээш хугацаанд дар.

Чихэвчийг мобайл төхөөрөмж рүү гараар дахин холбохын тулд мобайл төхөөрөмжийнхөө Galaxy Wearable дэлгэц дээр **Холбогдох** гэдгийг товш.

Өмнөх мобайл төхөөрөмжөөс салгасны дараа бусад төхөөрөмжтэй холбох

- 1 Мобайл төхөөрөмж дээрээсээ **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд, **Холболтууд** → **Bluetooth** дээр товшиж, дараа нь **Хослогдсон төхөөрөмжүүд** гэдгийн доор байгаа мобайл төхөөрөмжөөсөө чихэвчийг салгаж, чихэвчийг өмнөх мобайл төхөөрөмжөөс салгана.
- 2 Цэнэглэх хайрцгийг хааж, түүнийг дахин нээгээд Bluetooth хослуулах горимд орно уу. Эсвэл цэнэглэх хайрцгийг нээгээд, цэнэглэх хайрцгийн доод хэсэгт байрлах Холбогдох товчийг удаан дараад Bluetooth хослуулах горимыг оруулна.
- 3 Шинэ мобайл төхөөрөмж дээрээсээ **Galaxy Wearable** хэрэглүүрийг нээгээд дэлгэц дээрх зааврыг дагаж холболтыг гүйцээнэ үү.

Чихэвчтэй холбогдсон мобайл төхөөрөмжийн хооронд шилжих

Чихэвчийг нэгээс олон мобайл төхөөрөмжтэй холбосон бол өмнөх мобайл төхөөрөмжөөс салгахгүйгээр төхөөрөмжийг сольж болно.

Шилжихийг хүссэн мобайл төхөөрөмж дээрээ **Тохиргоо** хэрэглүүрийг нээж **Холболтууд** → **Bluetooth** дээр товшоод **Хослогдсон төхөөрөмжүүд** хэсэгт чихэвчээ сонго.



Таны чихэвч ба мобайл төхөөрөмжийн хоорондох холболтыг тухайн нөхцөлд автоматаар сольж болно. Жишээлбэл, таны чихэвч ижил Samsung бүртгэлээр нэвтэрсэн таблет, ухаалаг гар утсанд хоёуланд нь бүртгэгдсэн үед чихэвчний холболт автоматаар утас руу шилжсэнээс хойш таблет дээрх видеог үзэж байхдаа ухаалаг гар утаснаасаа дуудлага хүлээн авах боломжтой.

Galaxy Buds-ийн тохиргоог тохируулах

Танилцуулга

Таны мобайл төхөөрөмжтэй холбогдсон Galaxy Buds-ийн төлөвийг шалгаж, тэдний тохиргоог тохируулна.

Мобайл төхөөрөмж дээрээ **Galaxy Wearable** хэрэглүүрийг нээ.



- Android үйлдлийн системийн 16 буюу түүнээс дээш хувилбарыг ажиллуулж байгаа мобайл төхөөрөмж дээр чихэвчийг холбохдоо та Тохиргооны дэлгэцээс Galaxy Buds-н төлөвийг шалгаж, тохиргоог хийж болно. Мобайл төхөөрөм дээрх **Тохиргоо**-г нээгээд **Холболтууд** → **Bluetooth** товшиж, холбогдсон Galaxy Buds-н нэрийн хажууд байгаа  дээр товш.
- Дуу чимээг хянах эсвэл Vixby-н дуут сэрүүлэг зэрэг горимууд нь таны чихэвчийн ашиглалтын хугацаанд нөлөөлж болзошгүй.

Дуу чимээний хяналтын горимуудыг тохируулах

► **Galaxy Buds3:** Идэвхтэй дуу чимээг арилгах функцийг асаах эсвэл унтраана.

Мобайл төхөөрөмжийнхөө Galaxy Wearable дэлгэц дээрх **Идэвхтэй дуу чимээг цуцлах** сэлгүүрийг товшоод үүнийг асаана.

► **Galaxy Buds3 Pro:** Өөрийн нөхцөл байдал эсвэл эргэн тойрны орчинд тулгуурлан Орчны дуу, Дасан зохицох эсвэл Идэвхтэй дуу чимээг арилгах функцийг асааж эсвэл унтраана. Түүнчлэн, Орчны дууны горимыг автоматаар асааж тохируулах боломжтой.

Мобайл төхөөрөмжийнхөө Galaxy Wearable дэлгэц дээр функцийг сонгоод тохиргоог нь өөрчилнө.

- **Идэвхгүй:** Дуу чимээг хянах горимыг унтраана.
- **Орчны дуу:** Танд орчны дуу чимээг сонсох боломжийг олгоно.
- **Тааруулж болох:** Эргэн тойрны дуу чимээний хэмжээ эсвэл Идэвхтэй дуу чимээг эргэн тойрны дуу чимээний хэмжээний дагуу автоматаар арилгах хүчийг оновчтой болгохын тулд Дасан зохицох горимыг асаана.
- **Идэвхтэй дуу чимээг цуцлах:** Гадны дуу чимээг бууруулна.
- **Орчны дууны түвшин / Идэвхтэй дууг цуцлах түвшин:** Орчны дуу эсвэл Идэвхтэй дуу чимээг арилгах функцийг ажиллуулж байх үед эргэн тойрны дууны хэмжээ эсвэл Идэвхтэй дуу чимээг арилгах хүчийг өөрийн сонголтод нийцүүлэн тохируулна.
- **Орчны дуу чимээ рүү автоматаар шилжих:** Чихэвч яриа, дуут дохиог илрүүлэх, чихэвч зүүж байх үед дуудлага хийх зэрэг тодорхой нөхцөл байдалд эргэн тойрны нөхцөл байдал эсвэл харилцан ярианд анхаарлаа төвлөрүүлэхэд тань туслахын тулд орчны дууны автомат горим автоматаар асах болно.

Дууны чанар ба эффект

Та чихэвчийн дууны чанар болон дууны эффектийг тохируулах боломжтой.

Мобайл төхөөрөмжийнхөө Galaxy Wearable дэлгэц дээрх **Дууны чанар ба эффектүүд** дээр товш.

Дууны эффектүүд

- **360 аудио:** Медиаг үзэж байхад хүрээлэн буй орчныг 360 градусын хүрээлэх дуугаар хангана. Та мөн толгойныхоо хөдөлгөөнд тулгуурлан дууны чиглэлийг автоматаар тохируулах боломжтой.
 -  Энэ функц нь зөвхөн Android 11 One UI хувилбар 3.1 болон дараах хувилбартай мобайл төхөөрөмжид боломжтой бөгөөд мобайл төхөөрөмжийн загвараас хамааран боломжгүй байж болно.
 - Хэрэв та холбогдсон мобайл төхөөрөмжийг өөрт ойр байрлуулбал илүү сайн чанартай аудио сонсох боломжтой.
 - Медиа хэрхэн тоглодож байгаагаас шалтгаалж энэ функцийг дэмжихгүй байж магадгүй юм.
 - Дохиолол муутай газар байх үед мобайл төхөөрөмжтэй холбогдох холболт түр зуур тасарч болзошгүй юм.
- **Тогтворжуулагч:** Хэд хэдэн янзын жигдрүүлэгчийн сонголтоос сонгож нэг хөгжмийг өвөрмөц, өөр хөгөөр сонсож болно. Дэлгэрэнгүй мэдээллийг [Тэнцвэржүүлэгч ашиглах](#)-ээс авна уу.
- **Харилцан яриаг өсгөх:** Дуу хоолой нь видеонуудын арын дуу чимээнээс илүү тод сонсогддог.
- **Дуу чимээг хэвийн болгох:** Медиа тоглуулах явцад дуу гэнэт хэт чанга эсвэл хэт нам болохоос сэргийлнэ.
- **Дууг тохирохуйц тохируулах:** Чихэвч зүүх үед дууны эффектийг оновчтой болгохын тулд дууг автоматаар тохируулна. Хоёр чихэвч таны чихэнд яг таарч байх ёстой.

- **Чанарын дэвшилтэт сонголтууд**

- **Хэт өндөр чанартай (UHQ) аудио:** 96 кГц хүртэлх давтамжтайгаар анхны дуу чимээтэй ойролцоо дууны чанарыг мэдрээрэй.



Энэ функц идэвхтэй үед зарим функц ажиллахгүй байж магадгүй.

- **Супер өргөн бугуйвчны яриа:** 16 кГц зурвасын өргөнтэй дуудлагын тодорхой чанарыг хангана.

- **Чихэвч таарах эсэхийг турших:** Илүү сайн дуугаар хангах, Идэвхтэй дуу чимээг арилгах үүднээс утасгүй чихэвчийн тохируулгыг шалгана. (Galaxy Buds3 Pro)



- Холбогдсон мобайл төхөөрөмжөөс хамааран боломжит сонголтууд өөр байж болно.
- Чанарын дэвшилтэт сонголтуудыг ашиглах нь зайн зарцуулалтыг нэмэгдүүлнэ.

Чихэвчний удирдлагууд

Утасгүй чихэвчийн дохио зангааны функцийг тохируулна.

Мобайл төхөөрөмжийнхөө Galaxy Wearable дэлгэц дээр **Чихэвчний удирдлагууд** дээр товш.

- **Медиа удирдлагууд:** Медиа тоглуулах явцад та чихэвчийн дохио зангааны функцийг ашиглан хөгжим тоглуулах, түр зогсоох гэх мэтийг удирдах боломжтой. Дэлгэрэнгүй мэдээллийг [Дохио зангааг ойлгох](#)-ээс авна уу.

Удирдлагуудыг чимхээд барих

- **Зүүн:** Зүүн талын чихэвчийн хавчаад барих функцийг сонгоно.
- **Баруун:** Баруун талын чихэвчийн хавчаад барих функцийг сонгоно.



Дэлгэрэнгүй мэдээллийг [Хавчаад барих функцийг тохируулах](#)-ээс авна уу.

Дуудлагын удирдлага

- **Дуудлагад хариулах эсвэл дуудлагыг дуусгах:** Дуудлагад хариулах эсвэл дуусгахын тулд хавчина.
- **Дуудлагаас татгалзах:** Хавчаад барьж дуудлагаас татгалзана.
- **Чихэвчийн гэрлийн удирдлага:** Блэйд гэрлийн гэрэлтүүлгийн хэв маягийг өөрчилж, блэйд гэрлийг чихэвч дээр харагдуулна. Дэлгэрэнгүй мэдээллийг [Блэйд гэрэл \(Galaxy Buds3 Pro\)](#)-ээс авна уу. (Galaxy Buds3 Pro)



Холбогдсон мобайл төхөөрөмжөөс хамааран боломжит сонголтууд өөр байж болно.

Чихэвчийн тохиргоо

Утасгүй чихэвчтэй холбоотой мэдээллийг шалгаж, янз бүрийн тохиргоог өөрчилнө.

Мобайл төхөөрөмжийнхөө Galaxy Wearable дэлгэц дээр **Чихэвчийн тохиргоо** дээр товш.

Samsung account

Samsung бүртгэл рүүгээ нэвтэрч, удирдана уу.

Мобайл төхөөрөмжийнхөө Galaxy Wearable дэлгэц дээр **Чихэвчийн тохиргоо** → **Samsung account** дээр товш.

Дуут удирдлагууд

Ухаалаг дуу хоолойн туслах үйлчилгээний талаар яриа эхлүүлэхийн тулд Bixby-г дуу хоолойгоороо сэрээ.

Мобайл төхөөрөмжийнхөө Galaxy Wearable дэлгэц дээр **Чихэвчийн тохиргоо** → **Дуут удирдлагууд** дээр товшоод, **Bixby дуут сэрээх** сэлгүүрийг товшиж үүнийг асаана.

Хэрэв та **Дуут тушаал** сэлгүүрийг товшиж үүнийг асаавал Bixby руу залгахгүйгээр хүссэн үйлдлээ гүйцэтгэхийн тулд тохируулсан дуут командыг ашиглаж болно. Энэ функц нь зарим хэлийг дэмждэггүй.

Чихэн дээр илрүүлэх

Та чихэвч зүүсэн эсэхээ тогтоох, мобайл төхөөрөмж дээрээ дуудлага хүлээн авах эсвэл медиа тоглуулахыг түр зогсоохын тулд чихэвчийг тохируулж болно.

Мобайл төхөөрөмжийнхөө Galaxy Wearable дэлгэц дээр **Чихэвчийн тохиргоо** → **Чихэн дээр илрүүлэх** дээр товшоод, дараа нь сэлгүүрийг товшиж үүнийг асаана.

- **Хоёр чихэвчийг салгасны дараа дуудлагыг утас руу сэлгэнэ үү:** Та дуудлагын үеэр чихэвч зүүсэн эсэхийг илрүүлснээр чихэвч эсвэл мобайл төхөөрөмжөө дуудлага хийхээр тохируулах боломжтой. Энэ функц унтарсан бол чихэвч зүүгээгүй байсан ч дуудлага хийгчийн дуу хоолой чихэвч дээр тоглогдоно.
- **Нэг чихэвчийг салгах үед медиаг түр зогсоо:** Чихэвч зүүсэн эсэхийг илрүүлж, медиа тоглуулахыг түр зогсоож, үргэлжлүүлэхээр чихэвчийг тохируулна. Хэрэв энэ функцийг унтраасан бол чихэвчийг хоёуланг нь зүүгээгүй үед л медиа тоглуулах нь түр зогсоно.



Хэрэв та чихэвч зүүгээгүй байсан ч товшилт мэдрэгчийг арьсаараа халхалсан тохиолдолд чихэвчийг зүүсэн гэж илрүүлж болно.

Мэдэгдлийг чангаар унш

Та мобайл төхөөрөмжийн хэрэглүүрүүдээс чихэвчээр дамжуулан мэдэгдэх хүлээн авна.

Мобайл төхөөрөмжийнхөө Galaxy Wearable дэлгэц дээр **Чихэвчийн тохиргоо** → **Мэдэгдлийг чангаар унш** дээр товш.

-  : Та мэдэгдэл хүлээн авах хэрэглүүр хайх боломжтой.
- **Утсаа ашиглах үеэр чанга унших:** Мобайл төхөөрөмжийг хэрэглэж байсан ч чихэвчид мобайл төхөөрөмжийн мэдэгдлийг хүлээн авахаар тохируулна.
- **Бүгдийг зөвшөөрөх:** Та чихэвчээрээ дамжуулан бүх хэрэглүүрээс мэдэгдэл хүлээн авч, хэрэглүүр бүрийн мэдэгдлийн тохиргоог өөрчлөх боломжтой. Хэрэглүүрийн мэдэгдлийг өөрөөр хүлээн авах эсэхээ тохируулахын тулд хэрэглүүрийн хажууд байрлах сэлгүүрийг товшино. Та мөн **Бүгд** гэдгийг товшоод мэдэгдэл унших эсвэл уншихгүй гэж тохируулсан хэрэглүүрүүдийг харах боломжтой.

Утасгүй чихэвчийн холболт

Та чихэвчээ холбохын тулд мобайл төхөөрөмжийг өөрчилж болно. Та одоогийн мобайл төхөөрөмжөөс ижил Samsung бүртгэлээр нэвтэрсэн ойролцоох мобайл төхөөрөмж эсвэл өмнө нь утасгүй чихэвчээр холбогдож байсан төхөөрөмж рүү холболтыг шилжүүлэх функцийг асааж болно.

Мобайл төхөөрөмжийнхөө Galaxy Wearable дэлгэц дээр **Чихэвчийн тохиргоо** → **Утасгүй чихэвчийн холболт** дээр товшоод, сэлгүүрийг товшиж үүнийг асаана.



Чихэвчээ өөр хүний мобайл төхөөрөмжид холбохоос болгоомжил.

Хүзүүний сунгалт хийх сануулга

Таны чихэвч таны толгойг 10 минутаас дээш хугацаанд бөхийлгөж байгааг илрүүлэх үед та дууг сонсож, таны мобайл төхөөрөмж танд сунгалт хийхийг дэмжсэн дэлгэцийг харуулах бөгөөд ингэснээр хүзүүний сунгалтын энгийн дасгалуудыг хийж болно.

Мобайл төхөөрөмжийнхөө Galaxy Wearable дэлгэц дээр **Чихэвчийн тохиргоо** → **Хүзүүний сунгалт хийх сануулга** дээр товшоод, сэлгүүрийг товшиж үүнийг асаана.

Энэ функцийг анх удаа эхлүүлэх эсвэл өгөгдлийг дахин тохируулсны дараа уг функцийг тохируулахын тулд та чихэвчийг тохируулах шаардлагатай. Тохиргоог дуусгахын тулд дэлгэцэн дээрх зааврыг дагана уу.



- Утасгүй чихэвчийг таны хөдөлгөөнийг үнэн зөв танихын тулд тохируулаарай. Тохируулга хийх үед суух, зогсох зэргээр биеэ хөдөлгөж болохгүй.
- Хэрэв хэн нэгэн таны чихэвчийг ашиглаж байгаа эсвэл чихэвчийн хөдөлгөөн таних функц буруу байвал дахин тохируулна уу.
- Хэрэв та хөдөлж байвал толгойгоо доошоо 10 минутаас дээш бөхийлгөсөн ч дуу гарахгүй.
- Энэ функц чихэвчийг хоёуланг нь зүүсэн үед л ажилладаг.

Лабууд

Шинэ чихэвчийн функцүүдийг ашиглаарай.

Мобайл төхөөрөмжийнхөө Galaxy Wearable дэлгэц дээр **Чихэвчийн тохиргоо** → **Лабууд** дээр товш.

- **Тоглоомын горим:** Видео болон дууны гаралтын хоорондох хоцролтыг арилгахын тулд аудио саатлыг багасгаж, тоглоом тоглох бүрд зөв синк хийгдсэн аудио сонсоорой.



Зөвхөн Android OS үйлдлийн систем бүхий Samsung мобайл төхөөрөмжид энэ функцийг ашиглах боломжтой.

Дахин тохируулах

Та чихэвчүүдийн тохиргоог шинээр тохируулж болно.

Мобайл төхөөрөмжийнхөө Galaxy Wearable дэлгэц дээр **Чихэвчийн тохиргоо** → **Дахин тохируулах** дээр товш.

Хандалтыг хялбаршуулах

Утасгүй чихэвчийн хүртээмжийг сайжруулахын тулд янз бүрийн тохиргоог тохируулна уу.

Мобайл төхөөрөмжийнхөө Galaxy Wearable дэлгэц дээр **Чихэвчийн тохиргоо** → **Хандалтыг хялбаршуулах** дээр товш.

- **Зүүн/баруун дууны хэмжээ:** Хэрэв та сонсголын бэрхшээлтэй эсвэл ганц чихэвч ашиглах нь илүү тохиромжтой бол зүүн, баруун дууны түвшний тэнцвэрийг тохируулна. Балансыг тохируулахын тулд **Зүүн/баруун дууны хэмжээ** тохируулах мөрийг чирнэ үү. Хэрэв та мөрийг зүүн тийш чирвэл зүүн чихэвчний хэмжээ нэмэгдэх ба эсрэгээрээ байж болно.
- **Нэг чихэвчээр дуу чимээ удирдах:** Зөвхөн нэг чихэвч зүүсэн байсан ч дуу чимээг хянах горимыг асаана.

- **Орчны дууны сонсголын сайжруулалт:** Өөрийн сонсгол болон сонголтод тохируулан дууг тохируулна. (Galaxy Buds3 Pro)
 - **Орчны дууны түвшин:** Зүүн, баруун талын тохируулгын мөрийг чирж зүүн болон баруун орчны дууны хэмжээг тохируулна.
 - **Дууг урдаа чанга гаргах:** Урдаас ирж буй дуу хоолойг илүү сонсогдуулна. Та мөн **Арын дуу чимээг бууруулах түвшин** тохируулгын мөрийг чирж арын дуу чимээг бууруулах хэмжээг тохируулах боломжтой.
- **Орчны дууг тааруулах:** Сонсгол алдагдсанаас болж эргэн тойрныхоо дуу чимээг сонсоход бэрхшээлтэй хүмүүст туслахын тулд Galaxy Buds-ийг тохируулна. (Galaxy Buds3 Pro)

Чихэвч.н прог хангмж.н шинэчлэл

Чихэвчийн программ хангамжийг Техникийн программыг агаараар дамжуулах (FOTA) үйлчилгээгээр дамжуулан шинэчилнэ.

Мобайл төхөөрөмжийнхөө Galaxy Wearable дэлгэц дээр **Чихэвчийн тохиргоо** → **Чихэвч.н прог хангмж.н шинэчлэл** дээр товш.

- **Татаж авах ба суурилуулах:** Шинэчлэлтийг гараар шалгаж, суулгана уу.
- **Авто шинэчлэх:** Цэнэглэх хайрцагт чихэвчийг цэнэглэж байх үед автоматаар шинэчлэлт суулгахаар тохируулна уу.

Оношилгоо

Samsung Members ашиглан Galaxy Buds-аа туршиж үзээрэй.

Мобайл төхөөрөмжийнхөө Galaxy Wearable дэлгэц дээр **Чихэвчийн тохиргоо** → **Оношилгоо** дээр товш.

Чихэвчийн талаар

Galaxy Buds-ийн мэдээлэлд хандана.

Мобайл төхөөрөмжийнхөө Galaxy Wearable дэлгэц дээр **Чихэвчийн тохиргоо** → **Чихэвчийн талаар** дээр товш.

Galaxy Buds-ийнхаа нэрийг өөрчлөхийн тулд **Нэр солих** гэдгийг товшино уу.

- **Хууль эрх зүйн мэдээлэл:** Galaxy Buds-ийн эрх зүйн мэдээллийг харна.
- **Програм хангамжийн мэдээлэл:** Galaxy Buds-ийн программ хангамжийн мэдээллийг шалгана.
- **Зайны мэдээлэл:** Galaxy Buds-ийн зайн мэдээллийг шалгана.

Миний чихэвчийг олох

Хэрэв та чихэвчээ олохгүй байвал холбогдсон мобайл төхөөрөмждөө суулгасан Samsung Find хэрэглүүрийг ашиглан чихэвчээ олох боломжтой.

Мобайл төхөөрөмжийнхөө Galaxy Wearable дэлгэц дээр **Миний чихэвчийг олох** дээр товш.

Samsung Find хэрэглүүр таны мобайл төхөөрөмж дээр ажиллах бөгөөд та газрын зураг дээрээс чихэвчийнхээ байршлыг шалгах боломжтой. Мөн та загвараасаа хамааран чихэвчээс гарах дуу чимээг дагаж, эсвэл гарч буй дууг дагаж анивчих блэйд гэрлийг хайж чихэвчээ олох боломжтой.



- Samsung Find хэрэглүүрийн дэмжлэг нь холбогдсон мобайл төхөөрөмжийн программ хангамжийн хувилбараас хамаарч харилцан адилгүй байж болно.
- Samsung Find хэрэглүүрийг ашиглан чихэвчээ олохын тулд Samsung Find-ийн Гээсэн горимыг асаасан байх ёстой бөгөөд төхөөрөмжийг офлайнаар хайхтай холбоотой онцлогуудыг мөн асаасан байх ёстой.
- Таны хайж байгаа утасгүй чихэвч цэнэглэх хайрцаг дотор байхгүй бол ойр орчмыг хайж утасгүй чихэвчийг олоход 4 минут эсвэл түүнээс дээш хугацааг авч болно.

Хэрэглээний талаарх мэдэгдэл

Төхөөрөмжийг ашиглахтай холбоотой сануулга

Төхөөрөмжийг аюулгүй зөв хэрэглэхийн тулд энэ зааврыг уншина уу.

- Тайлбаруудыг төхөөрөмжийн үндсэн тохиргоонд үндэслэн хийсэн.
- Бүс нутаг, үйлчилгээ үзүүлэгч, загварын үзүүлэлт, төхөөрөмжийн программ хангамжийн хувилбар зэргээс хамааран зарим агуулга нь таны авсан төхөөрөмжөөс өөр байж болно.
- Бусад мобайл төхөөрөмжийг хэрэглэхийн өмнө тэдгээр нь энэ төхөөрөмжтэй нийцэх эсэхийг шалгана уу. Samsung веб хуудсанд зочилж нийцэх мобайл төхөөрөмжийн үзүүлэлтүүдийг шалгана уу.
- Энэ төхөөрөмжид өгөгдсөн программ хангамж, дууны эх үүсвэр, ханын зураг, зураг болон бусад зөөвөрлөгчийг хязгаарлагдмал ашиглах зөвшөөрөлтэй. Эдгээр материалыг арилжааны болон бусад зорилгоор задлах, ашиглах нь зохиогчийн эрхийн хуулийг зөрчсөн явдал юм. Хэвлэл мэдээллийн хэрэгслийг хууль бусаар ашигласан тохиолдолд хэрэглэгчид бүрэн хариуцлага хүлээнэ.
- Төхөөрөмжид дагалдаж ирдэг өгөгдмөл хэрэглүүрүүд нь шинэчлэлттэй байх бөгөөд урьдчилан мэдэгдэлгүйгээр цаашид дэмжигдэхгүй.
- Төхөөрөмжийн үйлдлийн системийг өөрчлөх буюу албан бус эхээс программ хангамжийг суурилуулбал төхөөрөмж алдаатай ажиллах эсвэл мэдээлэл эвдэрч алдагдаж болзошгүй. Тус үйлдэл нь Samsung-ийн лицензийн гэрээг зөрчиж таны баталгааг хүчингүй болгоно.
- Таны энэ төхөөрөмжтэй холбосон төхөөрөмжийн үйлдвэрлэгчээс хамаараад зарим функц энэ гарын авлагад тодорхойлсон ёсоор ажиллахгүй байж болзошгүй.
- Энэ бүтээгдэхүүн хэд хэдэн үнэгүй/нээлттэй эхийн программ хангамжийг агуулна. Энэ бүтээгдэхүүнд ашигласан нээлттэй эх сурвалжийн программ хангамжийн лицензийн мэдээллийг opensource.samsung.com-с олох боломжтой.
- Таны төхөөрөмж соронзонтой. Кредит карт, суулгасан эмнэлгийн хэрэгсэл болон соронзны нөлөөнд өртөж болзошгүй бусад төхөөрөмжөөс хол байлга. Эмнэлгийн хэрэгслийн хувьд төхөөрөмжөө 15 см-ээс хол зайд байлга. Хэрэв та өөрийн эмнэлгийн хэрэгслийг нөлөөлж болзошгүй гэж сэжиглэж байгаа бол төхөөрөмжөө ашиглахаа зогсоож, эмч эсвэл эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэгчтэйгээ зөвлөлдөнө үү.
- Энэ бүтээгдэхүүн нь соронз ашиглан ажилладаг. Төхөөрөмжөө соронзтой орчинд бүү хадгал. Ингэх нь доголдол үүсгэж болзошгүй.

Заавар шигтгээ зурагнууд



Анхаар: өөрийгөө болон бусдыг гэмтээж болох нөхцөл байдлууд



Санамж: таны төхөөрөмжийг болон бусад төхөөрөмжийг эвдэлж болзошгүй нөхцөл байдлууд



Тэмдэглэл: тэмдэглэл, хэрэглээний санамж, буюу бусад мэдээллүүд

Багцын агуулга, дагалдах хэрэгслийн талаарх ТЭМДЭГЛЭЛ

Багцын агуулгыг үзэхийн тулд товч зааврыг үз.

- Galaxy Buds-тай цуг өгсөн зүйлс, аливаа боломжит хэрэгсэл нь тухайн бүс нутаг, үйлчилгээ үзүүлэгчээс хамаарч өөр байж болно.
- Дагалдах зүйлс нь зөвхөн энэ Galaxy Buds-д зориулагдсан бөгөөд бусад төхөөрөмжид тохирохгүй байж болно.
- Харагдац болон үзүүлэлтүүдийг урьдчилан мэдэгдэлгүйгээр өөрчилж болохгүй. Мөн зөөлөвчийн хэмжээ нь илүү сайн тохирохын тулд өөр өөр байж болно.
- Та өөрийн орон нутгийн Samsung жижиглэнгийн худалдаачдаас нэмэлт хэрэгслүүд худалдаж авах боломжтой. Худалдаж авахын өмнө тухайн хэрэгсэл таны Galaxy Buds-д тохирох эсэхийг шалгана уу.
- Samsung-гийн зөвшөөрсөн хэрэгслийг хэрэглэ. Зөвшөөрөгдөөгүй хэрэгслийг хэрэглэснээр баталгаат үйлчилгээнд хамрагдахгүй ажиллагааны асуудал эвдрэл үүсгэж болно.
- Бүх хэрэгслийн бэлэн байлгах нь үйлдвэрлэгч компаний бүрэн хариуцаж өөрчлөх асуудал юм. Бэлэн хэрэгслийн талаар өшөө мэдээлэл авахыг хүсвэл Samsung-гийн вэбсайтнаас үзнэ үү.

Ус ба тоосны эсэргүүцлийг хадгалах

Таны төхөөрөмж ус, тоос шороонд тэсвэртэй бөгөөд дараах олон улсын стандартыг хангасан. Цэнэглэх хайрцаг нь усанд тэсвэргүй.

- IP57 ус тэсвэрлэх зэрэглэлийн гэрчилгээ: IEC 60529 стандартын шаардлагын дагуу 15—35°C, 86—106 кПа, 1 м цэвэр усанд 30 минут хөдөлгөөнгүй байлгаж туршсан.

Төхөөрөмжийнхөө ус болон тоос шороо тэсвэрлэх чадварыг хангахын тулд доорх зөвлөмжийг анхааралтай дагаарай.

- Төхөөрөмжүүдийг усан сан, далайн усанд хүргэхээс зайлсхий.
- Төхөөрөмжийг бохир ус, савантай ус, тос, үнэртэй ус, нарнаас хамгаалах тос, гар цэвэрлэгч, гоо сайхны бүтээгдэхүүн зэрэг химийн бүтээгдэхүүн, спирт агуулсан шингэн зэрэг бусад шингэнд бүү хүргэ.
- Төхөөрөмжийг хүчээр эсвэл урсгал усаар хөдөлж буй усанд бүү хүргээрэй.
- Усанд сэлэх, усан спортоор хичээллэх, шүршүүрт орохдоо төхөөрөмжөө бүү зүү.
- Температур нь хэвийн хэмжээнээс өндөр эсвэл саун гэх мэт чийгшил ихтэй газарт төхөөрөмжийг бүү ашигла.
- Төхөөрөмжийг унагаж эсвэл хүнд юманд цохиулж болохгүй.
- Төхөөрөмжийг угаалгын машин эсвэл хатаах машинд хийж болохгүй.

Хэрэв төхөөрөмжийг усанд хүргэж эсвэл бохирдуулсан бол доорх зааврыг дагана уу:

- Хэрэв төхөөрөмжүүдийг цэвэр усанд унагасан бол чихэвчийг уснаас гаргаж сэгсрээд, цэвэрхэн, зөөлөн даавуугаар сайтар арчиж, хатаана.
- Хэрэв төхөөрөмжүүд цэвэр уснаас бусад шингэнээр бохирдсон эсвэл түүнд байлгасан бол тэдгээрийг зөвхөн Samsung үйлчилгээний төв эсвэл эрх бүхий үйлчилгээний төвд засварласны дараа ашиглана уу.

Төхөөрөмжүүдийг усан дор ашиглахыг зөвлөөгүй.

Утасгүй чихэвчийг ашиглахтай холбоотой сануулга

- Чанга дуунд хэт их өртвөл сонсгол гэмтдэг.
- Алхаж байхдаа утасгүй чихэвчийг ашиглах нь таны анхаарлыг сарниулж, осол гарахад хүргэж болно.
- Чихэвчийг аудио оролтын үүрэнд холбохоос өмнө дууг үргэлж намсгаж бай, мөн яриа эсвэл хөгжим сонсоход хангалттай хэмжээнд л дууг чангалж бай.
- Хэрэв таны чих эсвэл утасгүй чихэвч чийгтэй эсвэл гадны материал болсон, эсвэл утасгүй чихэвч арьсанд удаан хугацаагаар хүрсэн бол энэ нь арьсыг цочроож болзошгүй. Утасгүй чихэвчийг зүүхээсээ өмнө чих болон утасгүй чихэвч цэвэр, хуурай байгаа эсэхийг шалгаарай.
- Хуурай орчинд, чихэвч дотор цахилгаанжилт үүсэж болдог. Чихэвчийг хуурай орчинд ашиглахаас зайлсхий, эсвэл чихэвчийг холбохоос өмнө металл эд зүйлд хүргэж цахилгаанжилтыг арилга.
- Жолоо барьж байх эсвэл дугуй унаж байхдаа чихэвч бүү ашигла. Ингэсэн тохиолдолд таны анхаарал сарниж, осол гарахад хүргэж болзошгүй эсвэл таны оршин суугаа газарт хөдөлгөөнд оролцох үед чихэвч зүүх нь хууль бус байдаг байж болно.
- Galaxy Buds нь олон улсын аюулгүй байдлын стандартыг дагаж мөрддөг боловч утасгүй чихэвчийг хүчээр оруулах эсвэл удаан зүүх нь өвдөлт, арьсанд цочрол үүсгэж болзошгүй.
- Хэрэв утасгүй чихэвчийг зүүсэн үед арьсанд ямар нэгэн цочрол өгвөл нэн даруй зүүхээ больж, мэргэжлийн эмчид хандана уу.
- Тоос, хөлс, бэх, тос, химийн бодис (гоо сайхны бүтээгдэхүүн, нарнаас хамгаалах тос, бактерийн эсрэг шүршигч, гар ариутгагч, угаалгын нунтаг, шавьж устгах бодис гэх мэт) чихэвч болон цэнэглэх хайрцагт тогтсон тохиолдолд, чихэвчээ шахсан агаараар цэвэрлэж, эсвэл хэт авианы долгион эсвэл гадны дулааны эх үүсвэр ашиглаж болохгүй. Өнгөний өөрчлөлт эсвэл ээврэлт нь Galaxy Buds-д гэмтэл учруулж болзошгүй.
- Зөөлөвчийг авч, гадна болон торон хэсгийг цэвэр усаар угааж, хэрэглэсний дараа сайтар хатаана. Хэрэв чихэвч бохирдсон бол зөөлөн, хуурай даавуугаар арчина.

Galaxy Buds-ийг цэвэрлэх, удирдах

Ердийн засвар үйлчилгээ

- Чихэвчийг хэрэглэсний дараа зөөлөн хуурай даагуугаар арчина.
- Чихэвчийг хуурай хадгална. Чихэвчид шингэх хүрэх, нэвтрэхээс сэргийл.
- Чихний хулхи, хогний өөдсийг микрофоны нүх, чанга яригч ба агаарын хоолойд байлгахгүйн тулд чихэвчийг тогтмол цэвэрлээрэй.

Микрофоны нүх, чанга яригч, агаарын хоолойг цэвэрлэх


Хэрэв дууны түвшин тухайн тохиргоонд байвал зохих хэмжээнээс доош байвал микрофоны нүх, чанга яригч болон агаарын хоолойг цэвэрлэ. Чанга яригчийг цэвэрлэхээс өмнө зөөлөвчийг чихэвчний доод талын түгжээнээс салгаж авна.

Цэвэрлэгээ, хуурай, зөөлөн сойз, хөвөн алчуур болон бусад хэрэгслээр чихний залгуур, хог хаягдлыг арилгана.


► Galaxy Buds3:



Микрофоны нүх




Чанга яригч




Агаарын хоолой


► Galaxy Buds3 Pro:



Микрофоны нүх



Чанга яригч




Агаарын хоолой



Наалдсан хулхи, тоосыг арилгахдаа ямар нэг хурц үзүүртэй зүйл эсвэл хэт хүчилж болохгүй. Микрофоны нүх, чанга яригч болон агаарын хоолой эвдэрсэн байж болзошгүй.

Цэнэглэх холболтыг цэвэрлэх

Зайг зохих ёсоор цэнэглэхгүй байвал цэнэглэгч холболтыг хуурай алчуураар арч.



Цэнэглэх холболт

Чихэвч, цэнэглэх хайрцгийг цэвэрлэх

Цэнэглэх хайрцаг ба чихэвч тоос, элс, металлын үртэс зэрэг гаднын биетээр бохирдсон бол Galaxy Buds зохих ёсоор цэнэглэгдэхгүй эсвэл гэмтэж болзошгүй. Хэрэвч чихэвч эсвэл цэнэглэх хайрцагт гадны материал наалдсан бол цэнэглэх хайрцагт хийхийн өмнө зөөлөн хуурай даавуугаар арч.

Чихэвчийг унтрааж асаах

Хэрэв чихэвчийн дохио зангааны функц доголдсон эсвэл хариу үйлдэл үзүүлэхгүй, чихэвч зохих ёсоор ажиллахгүй байвал чихэвчийг унтрааж асаана.

Чихэвчийг унтрааж асаахын тулд чихэвчийг цэнэгтэй байгаа цэнэглэх хайрцгийн харгалзах үүрэнд хийж, цэнэглэх хайрцгийг хаагаад 7 секундээс илүү байлгаад гаргаж авна.



Хэрэв цэнэглэх хайрцгийн зайн цэнэг багассан бол эхлээд цэнэглэх хайрцгийг цэнэглэгчид залгана.

Чихэвчийг хослуулах

Хэрэв та өрөөсөн чихэвчээ гэсэн бол шинэ хос чихэвч худалдан авах хэрэггүй, учир нь нэг чихэвч шинээр худалдан аваад одоо байгаа чихэвчтэйгээ хослуулж болно.

- 1 Шинээр худалдан авсан, өмнө хэрэглэж байсан чихэвч бүрийн чиглэлийг шалгаж, цэнэглэх хайрцгийн харгалзах үүрэнд зөв байрлуулна.
- 2 Цэнэглэх хайрцгийг нээгээд, цэнэглэх хайрцгийн доод хэсэгт байрлах Холбогдох товчийг 7—20 секунд дар.
Цэнэглэх хайрцгийн зайн заагч гэрэл цэнхэр өнгөөр анивчиж байгаад унтарна. Дараа нь чихэвчүүд хосолно.



Хэрэв чихэвч зүй ёсоор хослоогүй бол утасгүй цэнэглэх хайрцгийн зайн заагч гэрэл улаанаар анивчсаар байна. Чихэвчийг цэнэглэх хайрцгаас гаргаад, буцаагаад хийнэ үү. Дараа нь цэнэглэх хайрцгийг нээгээд, цэнэглэх хайрцгийн доод хэсэгт байрлах Холбогдох товчийг 7—20 секунд дар. Хэрэв та Холбогдох товчийг 20 секундээс дээш удаан дарвал чихэвч дахин тохируулагдаж болзошгүй.

- 3 Утасгүй чихэвчийг мобайл төхөөрөмжтэй холбох.
Хоёр утасгүй чихэвчийн программ хангамжийн хувилбарууд өөр бол Galaxy Wearable хэрэглүүрийн зааврыг дагаж программ хангамжаа сайжруулна уу.

Хавсралт

Гэмтэл оношлох

Samsung-н засвар үйлчилгээний төв эсвэл зөвшөөрөлтэй засвар үйлчилгээний төвтэй холбогдохоос өмнө, дараах шийдлүүдийг туршиж үзнэ үү. Зарим тохиолдол нь таны Galaxy Buds-д таарахгүй байж болно.

Та мөн Samsung Members-ийг ашиглан төхөөрөмжөө ашиглах явцад гарч болох аливаа асуудлыг шийдэж болно.

Чихэвч ажиллахгүй болсон

- Зай бүрэн цэнэггүй болсон байж болно. Чихэвчийг хэрэглэхийн өмнө зайг бүрэн цэнэглэ.
- Хэрэв чихэвчийн товшилт мэдрэгч таны чихэнд хүрэлцэхгүй бол чихэвч ажиллахгүй байж болзошгүй. Хэрэв чихэвчийг таньсан тухай дуу сонсогдоогүй бол чихэвчийг чихнээсээ аваад, буцааж хийнэ үү.
- Хэрэв чихэвчийн дохио зангааны функц доголдсон, хариу үзүүлэхгүй эсвэл чихэвч зохих ёсоор ажиллахгүй бол чихэвчийг цэнэгтэй байгаа цэнэглэх хайрцгийн харгалзах үүрэнд хийж, цэнэглэх хайрцгийг хаагаад, 7 секундээс илүү байлгаад гаргаж авна.

Өөр нэг Bluetooth төхөөрөмж таны чихэвчийг олохгүй байх

- Цэнэглэх хайрцгийг дахин хааж, нээгээд Bluetooth хослуулах горимд оруул.
- Чихэвч болон нөгөө Bluetooth төхөөрөмжүүд Bluetooth-ийн холболтын хязгаар дотор (10 м) байвал зохино. Төхөөрөмжийг хэрэглэж буй орчны нөхцөлөөс хамааран зай янз бүр байна.

Хэрэв дээрх аргууд асуудлыг шийдвэрлэхгүй бол Samsung-н засвар үйлчилгээний төв эсвэл зөвшөөрөлтэй засвар үйлчилгээний төвтэй холбогдоно уу.

Bluetooth холболт хийгдээгүй эсвэл таны чихэвч ба мобайл төхөөрөмжийн холболт тасарсан байх

- Төхөөрөмжүүдийн хооронд хана, цахилгаан хэрэгсэл гэх мэт ямар нэгэн саад бэрхшээл гарахгүй эсэхийг шалгаарай.
- Гар утас дээр Galaxy Wearable хэрэглүүрийн хамгийн сүүлийн хувилбарыг суулгасан эсэхийг шалгаарай. Хэрэв Galaxy Wearable хэрэглүүр нь хамгийн сүүлийн хувилбар биш бол Galaxy Wearable хэрэглүүрийг хамгийн сүүлийн хувилбар болгож шинэчилнэ үү.
- Чихэвч болон нөгөө Bluetooth төхөөрөмжүүд Bluetooth-ийн холболтын хязгаар дотор (10 м) байвал зохино. Төхөөрөмжийг хэрэглэж буй орчны нөхцөлөөс хамааран зай янз бүр байна.
- Мобайл төхөөрөмжийг дахин эхлүүлж, **Galaxy Wearable** хэрэглүүрийг дахин нээ.
- Хэрэв өрөөсөн чихэвч мобайл төхөөрөмжтэй холбогдсон бол чихэвчийг унтрааж асаагаад хоёулыг холбо. Чихэвийг унтрааж асаах тухай [Чихэвчийг унтрааж асаах](#)-с дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.

Зай нь зохих ёсоор цэнэглэдэггүй (Samsung-с зөвшөөрсөн цэнэглэгчүүд)

- Чихэвчийн цэнэглэх үзүүр цэнэглэх хайрцгийн цэнэглэх холболт харилцан хүрэлцэж байвал зохино.
- Цэнэглэх хайрцгат цэнэглэгчийг зөв залгасан эсэхийг шалга.
- Хэрэв цэнэглэх холболт бохирдсон бол зайг зохих ёсоор цэнэглэхгүй байж болзошгүй. Цэнэглэж буй холболтуудаа хуурай даавуугаар арчиж, зайг дахин цэнэглээд үзээрэй.

Хэрэв дээрх аргууд асуудлыг шийдвэрлэхгүй бол Samsung-н засвар үйлчилгээний төв эсвэл зөвшөөрөлтэй засвар үйлчилгээний төвтэй холбогдоно уу.

Чихэвчүүдийн ээнэглэх хугацаа ба зайн ажиллах хугацаа ялгаатай болсон

- Хоёр чихэвчийг зэрэг цэнэглэж эхэлсэн ч цэнэглэх хугацаа ялгаатай байж болно.
- Чихэвч бүрд дотоод бүтэц өөр тул цэнэглэх хугацаа, зайн үлдэж буй цэнэг ялгаатай байж болно.

Зай нь анх худалдаж авсантай харьцуулахад хурдан багасдаг

- Galaxy Buds-ийг хэт халуун эсвэл хэт хүйтэн хэмд байлгавал ашигтай цэнэг багасаж болзошгүй.
- Зай нь цэнэглэгдэх бөгөөд ашиг тустай цэнэг нь цаг хугацааны хувьд богино байх болно.
- Утасгүй чихэвчийг хэрэглээгүй үедээ цэнэгтэй цэнэглэх хайрцагт хадгал. Үгүй бол товшилт мэдрэгч үргэлжлүүлэн ажиллах бөгөөд энэ нь ашиглалтын хугацаа болон зайн зарцуулалтад нөлөөлнө.

Бусдын яриаг сонсогдохгүй байна

Холбогдсон мобайл төхөөрөмжид дууны түвшнийг тааруул.

Дуудлагын үеэр дуу чимээ гарна

Холбогдсон мобайл төхөөрөмжид дууны түвшнийг тааруулах юм уу өөр газар оч.

Дуудлагын үеэр дуу чимээ чихэвчнээс биш холбогдсон мобайл төхөөрөмжөөс гардаг

- Чихэвчээ зөв зүүсэн эсэхээ шалгаарай. Хэрэв зохисгүй зүүсэн бол, та холбогдсон мобайл төхөөрөмж дээр Bluetooth дүрс гарч ирсэн ч гэсэн дуудлагын дууг чихэвчээр дамжуулан сонсох боломжгүй юм.
- Чихэвчээ чихнээсээ гаргаж дахин зүүнэ үү.

Аудио дууны чанар муу байна

- Операторын сүлжээний асуудлаас болж утасгүй сүлжээний үйлчилгээ идэвхгүй болсон байж магадгүй. Чихэвчийг цахилгаан соронзон долгионоос хол байлга.
- Чихэвч болон нөгөө Bluetooth төхөөрөмжүүд Bluetooth-ийн холболтын хязгаар дотор (10 м) байвал зохино. Төхөөрөмжийг хэрэглэж буй орчны нөхцөлөөс хамааран зай янз бүр байна.
- Холбогдсон төхөөрөмжийн дууны түвшнээс хамаараад дууны түвшин унах, шуугих зэрэг байдал илэрч болно. Үүнээс сэргийлэхийн тулд холбогдсон төхөөрөмжийн дууг зохих ёсоор тааруулна уу.

Видео тоглуулах, тоглох үед чихэвчний дуу дэлгэцэд байгаагаас удаашрах

Видео тоглуулах, тоглох үеэр дууны гаралтын хооронд мобайл төхөөрөмжтэй холбогдсон чихэвчид хоцрол үүсэж байж магадгүй.

Дуу чимээг хянах горим нь сайн ажиллахгүй байх

- Чихэндээ хоёр чихэвчээ зүүж, дуу чимээг хянах горимуудын нэг болох Идэвхтэй дуу чимээ арилгах функцийг ажиллуулаарай. Хэрэв та Идэвхтэй дуу чимээг арилгах функц ассан гэдэгт эргэлзэж байгаа бол үүнийг Galaxy Wearable хэрэглүүр дээрээс шалгана уу.
- Чихэвчний дээд ба доод хэсэгт байрлах микрофонд гадны материалын хуримтлал байгаа эсэхийг шалгаж, шаардлагатай бол цэвэрлэ.
- Чихэвчид програм хангамжийн хамгийн сүүлийн хувилбар суулгасан эсэхийг шалгаарай.

Galaxy Buds хүрэхэд халсан байх

Galaxy Buds-ийг удаан хугацаагаар хэрэглэвэл хүрэхэд тэд халсан байж болно. Энэ нь хэвийн үзэгдэл бөгөөд Galaxy Buds-ийн эдэлгээний хугацаа эсвэл гүйцэтгэлд ямар нэг нөлөө үзүүлэхгүй.

Хэрэв Galaxy Buds хэт халсан буюу удаан хугацааны турш халж мэдрэгдвэл хэсэг хугацаанд бүү хэрэглэ. Хэрэв Galaxy Buds хэт халсан хэвээр байвал Samsung-н засвар үйлчилгээний төв эсвэл зөвшөөрөлтэй засвар үйлчилгээний төвд хандана уу.

Galaxy Buds-ийн гадна талд жижиг завсар бий болох

- Энэ ялгаа нь үйлдвэрлэлийн зайлшгүй шинж чанар бөгөөд зарим хэсэгт хэлбэлзэл эсвэл чичиргээ үүсэж болзошгүй юм.
- Цаг хугацаа өнгөрөхөд хэсгүүдийн хоорондох үрэлт энэ завсрыг бага зэрэг тэлэхэд хүргэдэг.

Утасгүй чихэвчийг чихнээсээ салгах үед зөөлөвч доошоо харсан байдаг (Galaxy Buds3 Pro)

Чихэвчийг хэрхэн зүүх, чихнээсээ салгах чиглэлээс хамаарч зөөлөвч эргэж болно. Энэ тохиолдолд тэдгээрийг анхны чиглэлд эргүүлж, дахин ашиглана уу.

Зохиогчийн эрх

Зохиогчийн эрх © 2025 Samsung Electronics Co., Ltd.

Энэхүү заавар нь олон улсын зохиогчийн эрхийн хуулийн дагуу хамгаалагдсан.

Энэхүү зааврын аль ч хэсгийг хуулбарлах, бичлэг хийх, аливаа мэдээллийн хадгалах санд болон буцааж авах системд хадгалах, хуулбарлах, бичлэг хийх, хадгалах гэх мэт ямар ч хэлбэрээр, цахим болон механик байдлаар хуулбарлах, тараах, орчуулах, дамжуулах боломжгүй.

Худалдааны тэмдэг

- SAMSUNG болон SAMSUNG-ийн лого нь Samsung Electronics Co., Ltd. компанийн бүртгэлтэй худалдааны тэмдгүүд юм.
- Bluetooth® нь олон улсын Bluetooth SIG, Inc. байгууллагын бүртгэлтэй худалдааны тэмдэг юм.
- Бусад бүх худалдааны тэмдэг болон зохиогчийн эрхүүд нь тэдний холбогдох эздийн өмч юм.

Загвар: SM-R530 / SM-R630

Нэрлэсэн хүчдэл/гүйдэл:

5 В / 200 мА (утасгүй чихэвч)

5 В / 900 мА (цэнэглэх хайрцаг), 3,88 В (доторх зай)

Samsung Вьетнамд үйлдвэрлэв

